МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН 2020 ОНЫ НАМРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАНЫ 12 ДУГААР САРЫН 17-НЫ ӨДӨР /ПҮРЭВ ГАРАГ/-ИЙН НЭГДСЭН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН ТОВЬЁГ

№	Баримтын агуулга	Хуудасны дугаар
1.	Хуралдааны товч тэмдэглэл:	1-15
2.	Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	16-141
	1.Төмөр замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.05.14-ний өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх, үргэлжилнэ/	17-20
	2.Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Тогтохсүрэн нарын 8 гишүүн 2020.04.22-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	20-53
	3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл /Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан, Ж.Ганбаатар нарын 2019.12.03-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	53-64
	4.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	65-92
	5.Эрдэнэсийн сангийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Улсын Их Хурлын гишүүн Ж.Бат-Эрдэнэ, С.Бямбацогт, Л.Мөнхбаатар нарын 3 гишүүн 2020.01.13-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	92-106
	6.Батлан хамгаалах салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Социалист Вьетнам Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	106-108
	7.Далайчныг сургах стандарт, гэрчилгээ олгох болон ээлжийн ажиллагааны тухай олон улсын конвенцын нэмэлт, өөрчлөлтийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	109-119
	8.Олон Улсын Эрүүгийн шүүхийн дархан эрх болон эрх ямбын тухай хэлэлцээрийг соёрхон батлах тухай хуулийн төсөл /Засгийн газар 2020.12.01-ний өдөр өргөн мэдүүлсэн, соёрхон батлах/	119-121

	9.Хөрөнгийн үнэлгээний тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2020.05.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, хэлэлцэх эсэх/	121-141

Хураангуй тэмдэглэл

Үдээс хойших хуралдаан 14 цаг 06 минутад эхлэв.

Чөлөөтэй: Х.Булгантуяа, Х.Нямбаатар, Л.Оюун-Эрдэнэ, Д.Өнөрболор, Ш.Раднаасэд, У.Хүрэлсүх, Ж.Чинбүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Н.Учрал, Б.Энх-Амгалан;

Тасалсан: А.Адъяасүрэн, Д.Ганбат, Н.Ганибал;

Хоцорсон: Б.Дэлгэрсайхан-40 минут, Г.Мөнхцэцэг-30 минут, Б.Саранчимэг-40 минут, Н.Энхболд-1 цаг 06 минут.

Дөрөв.Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд */Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар 2020.05.07-ны өдөр өргөн мэдүүлсэн,* ***хэлэлцэх эсэх****/*

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Хүний эрхийн Үндэсний Комиссын

гишүүн Х.Мөнхзул, Д.Сүнжид, Б.Энхболд, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын Хүний эрхийн хэлтсийн дарга Ц.Навчаа, “Оюутолгойн хяналт” Төрийн бус байгууллагын тэргүүн Д.Сүхгэрэл, “Хүний эрх хөгжил төв” Төрийн бус байгууллагын тэргүүн Г.Уранцоож, “Эмнести интернэшнл” Төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал Б.Алтантуяа нар “Их хуралдай” танхимаас оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Тэргүүн дэд дарга Н.Цогтсайхан, Хууль, эрх зүйн газрын дарга Э.Түвшинжаргал, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Батбаатар, Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Хууль зүйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх М.Үнэнбат, референт Л.Мөнхчимэг нар байлцав.

Төслийн үзэл баримтлалын талаар илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар “Их хуралдай” танхимаас, хуулийн төслийг хэлэлцэх эсэх талаар Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг “Жанжин Д.Сүхбаатар” танхимаас тус тус танилцуулав.

Илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Л.Энх-Амгалан, Ш.Адьшаа, Н.Наранбаатар, Ц.Сандаг-Очир, О.Цогтгэрэл, С.Одонтуяа, Б.Баярсайхан, Ж.Сүхбаатар, Л.Мөнхбаатар, М.Оюунчимэг, Х.Болорчулуун, Б.Бат-Эрдэнэ нарын тавьсан асуултад Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатар, Хууль зүйн байнгын хорооны дарга С.Бямбацогт, Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул, Д.Сүнжид, Б.Энхболд нар “Их хуралдай” танхимаас хариулж, тайлбар хийв*./Танхим тус бүрийн нэр өгсөн дараалыг сөөлжүүлэн асуулт асуух зөвшөөрөл өгсөн болно/*

Улсын Их Хурлын гишүүн Т.Аюурсайхан, Ц.Мөнхцэцэг, О.Цогтгэрэл, Ц.Даваасүрэн, С.Амарсайхан нар үг хэлэв.

Г.Занданшатар: Байнгын хорооны саналаар Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 43
Татгалзсан: 20
Бүгд: 63
68.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тул анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлэв.

Уг асуудлыг 15 цаг 45 минутад хэлэлцэж дуусав.

Дэлгэрэнгүй тэмдэглэл

Г.Занданшатар: Улсын Их Хурлын 12 сарын 17-ны өдрийн үдээс хойших нэгдсэн хуралдаан нээснийг мэдэгдье. Ингээд хэлэлцэх асуудалдаа орно. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцэнэ.

Хууль санаачлагчийн илтгэлийг Улсын Их Хурлын гишүүн Дамдины Цогтбаатар индрээс танилцуулна. Дамдины Цогтбаатар гишүүнийг индэрт урьж байна.

Ажлын хэсгийг дараа нь танилцуулна. Ажлын хэсэг орж ирээд сууцгаая. Ингээд индэрт ганцаараа сууж байгаа учраас маскаа авлаа.

Д.Цогтбаатар: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин зургаадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 1.3 дахь заалтад заасан бүрэн эрхийнхээ дагуу Монгол Улсын хууль тогтоомжийн тухай хуулийг үндэслэн Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг Хүний эрхийн Үндэсний Комисс болон хүний эрхийн чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудтай хамтран боловсруулснаа чуулганы нэгдсэн хуралдаанд ийнхүү танилцуулж байна.

Манай улсад хүний эрхийг хамгаалах үйл ажиллагаа явуулсны төлөө амь нас, бие махбодод нь халдах, заналхийлэх, дарамт шахалтад өртөх явдал цөөнгүй гарч байгаа ч хүний эрх хамгаалагчийг хамгаалах, үйл ажиллагааг нь дэмжих эрх зүйн орчин гүйцэд бүрдээгүй байна. Хүний эрхийг хамгаалагчийн үйл ажиллагааны баталгаа, хамгаалалтыг хууль тогтоомжоор дэмжих зорилгоор дэлхийн 40 гаруй улс хүний эрх хамгаалагчийн эрхийг баталгаажуулсан хууль, тогтоомжийг баталсан байна.

Хүний эрхийн Үндэсний Комиссоос 2014 онд шүүгч, прокурор, цагдаагийн

байгууллагын албан хаагч, өмгөөлөгч, хэвлэл мэдээллийн байгууллагын ажилтан, сэтгүүлч, иргэний нийгмийн байгууллагын ажилтан, хүний эрхийг хамгаалагч, идэвхтэн зэрэг 1375, үйлдвэрчний эвлэлийн байгууллагад ажиллаж буй хүний эрх хамгаалагчийн үйл ажиллагааны баталгаа, судалгаанд Улаанбаатар хот, 21 аймгаас үйлдвэрчний эвлэлийн гишүүн, идэвхтэн сонгуульт ажилтан 3662 хүнийг хамруулан хийсэн судалгаагаар хүний эрхийг хамгаалж ажилласных нь төлөө амь нас, бие махбодод нь халдах, заналхийлэх, нэр төр, алдар хүндэд нь халдах, сэтгэл санааны дарамт үзүүлэх, цахим хэлбэрээр халдах, мэдээлэл авах боломжийг нь хязгаарлах, мэдээлэл өгөхөөс татгалзах, үйл ажиллагааг нь үгүйсгэх, үл ялгаварлах, шударга бус хандах, үзэл бодлоо илэрхийлэх эрхийг нь хязгаарлах зэрэг хүндрэл бэрхшээл жил тутам нэмэгдэж амь насаа алдах олон төрлийн дарамт шахалтад орох нь түгээмэл болжээ. Эдгээрээс нэр төр, алдар хүндэд халдах, доромжлох, сэтгэл санааны дарамт, шахалт, заналхийлэлд өртөх явдал хамгийн их буюу нийт судалгаанд оролцогчдын 38 хувийг эзэлж байна.

Иймд хүний эрхийг хамгаалагчийг хуулиар анх удаа тодорхойлон, тэдний эрх зүйн байдлыг бие даасан хуулиар баталгаажуулж, хүний эрхийн хамгаалагчийн аюулгүй байдлыг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээх, сэргээн эдлүүлэх тогтолцоог байгуулах үүднээс энэхүү хуулийн төслийг боловсруулаа.

Хуулийн төсөл нь Монгол Улсын Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хууль, Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуультай харилцан уялдаатай боловсруулагдсан болно.

Хуулийн төсөл батлагдсанаар хүний эрх хамгаалагч гэх нэрийн дор хууль бус үйл ажиллагаа явуулах, улс төрийн шинжтэй, зохион байгуулалттай захиалгат гүтгэлэг тараах зэрэг үйл ажиллагаа хязгаарлагдаж, хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдал тодорхой болохоос гадна хүний эрхийг хамгаалагч түүний үйл ажиллагааг тодорхойлох, иргэний нийгмийг хөхүүлэн дэмжих, хараат бус ажиллах эрх мэдлийн хувьд гадуурхагдсан этгээдийг хамгаалж, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлдэг хүний эрхийн түгээмэл соёл, төлөвших нөхцөл бүрдэнэ гэж үзэж байна.

Хуулийн төсөл батлагдсанаар хүний эрхийг хамгаалах одоогийн тогтолцоог улам бүр бэхжүүлэх замаар хүмүүнлэг, иргэний ардчилсан нийгмийг цогцлоон хөгжүүлэх Үндсэн хуулийн эрхэм зорилгод хүрэхэд нэг шат ахих боломж бүрдэх юм.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүний эрхийг хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төслийг хэлэлцэн дэмжиж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар:Төслийн талаар Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Цэрэнжамцын Мөнхцэцэг Жанжин Д.Сүхбаатарын танхимаас танилцуулна.

Ц.Мөнхцэцэг: Улсын Их Хурлын дарга, эрхэм гишүүд ээ,

Улсын Их Хурлын гишүүн Д.Цогтбаатараас 2020 оны 5 дугаар сарын 07-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн хэлэлцэх эсэх асуудлыг Хууль зүйн байнгын хороо 2020 оны 12 дугаар сарын 15-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль санаачлагч хүний эрхийн хамгаалагч гэж хэн болох, хүний эрхийн хамгаалагчид халдсан халдлага, гомдлыг бүртгэх, баримтжуулах, тэдгээрийн аюулгүй байдлыг хангах, зөрчигдсөн эрхийг сэргээн эдлүүлэх, хүний эрхийн хамгаалагчид халдсан зөрчлийг шийдвэрлэх зорилгоор тус хуулийн төслийг боловсруулсан байна.

Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслүүдийг хэлэлцэх явцад Улсын Их Хурлын гишүүн Адьшаа гадаадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн эрхийг хамгаалах асуудал төсөлд хэрхэн туссан талаар, Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар хүний эрхийн хамгаалагчийн хамгаалах чиг үүргийг Хүний эрхийн Үндэсний Комиссын дэргэдэх хүний эрхийн хамгаалагчийн хороо хэрэгжүүлэх нь оновчтой эсэх асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг Хүний эрх хамгаалагчийн хороо нь бусад байгууллагатай хэрхэн харилцах, хорооноос гарах шийдвэрийн төрөл, түүний хэрэгжилтийг хангах асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн Д.Ганбат хуулийн төслийг баталснаар хүний эрхийн зөрчлийн асуудлыг нэг мөр шийдэж чадах эсэх асуудлаар, Улсын Их Хурлын гишүүн Бямбацогт Улсын Их Хурал Хүний эрхийн Үндэсний Комиссын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг баталж, хүний эрхийн хамгаалах үйл ажиллагааг өргөн хүрээнд явуулах эрх зүйн тогтолцоо суурийг бүрдүүлсэн бөгөөд хуулийн төсөлд заасан хүний эрхийг хамгаалагчийн хороо байгуулах нь зайлшгүй шаардлагатай эсэх талаар, түүнчлэн гүтгэн доромжлох, үзэл бодлоо илэрхийлэх эрхийн зааг ялгааны асуудлаар тус тус асуулт асууж, хариулт авсан болно.

Улсын Их Хурлын гишүүн Сүхбаатар ажлын хэсэг байгуулж, хуулийн төслийг нухацтай ярилцаж, олон нийтийн санаа бодлыг сонсох, хэлэлцүүлэг зохион байгуулах нь зүйтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн Б.Энхбаяр хүний эрхийг хамгаалах асуудал дээр төр нэг бодлоготой байх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүн Алтанхуяг хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа хэдий ч хүний эрхийн хамгаалагчийн хороо байгуулах асуудлыг дэмжихгүй байгаа талаар, Улсын Их Хурлын гишүүн Дэлгэрсайхан хүний эрхийн асуудалтай зэрэгцээд үүргийн асуудлыг авч үзэх шаардлагатай талаар, Улсын Их Хурлын гишүүндээ Сандаг-Очир хүн бүр эрхийн хамгаалагч гэдэг ойлголтыг төлөвшүүлэх асуудлыг ач холбогдлын талаар онцолж, хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд дэмжиж байгаа талаар тус тус санал хэлсэн болно.

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь үзэл баримтлалын хүрээнд дэмжиж, чуулганы

нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Г.Занданшатар: Мөнхцэцэг гишүүнд баярлалаа.

Ажлын хэсгийн гишүүдийг танилцуулъя. Хүний эрхийн Үндэсний Комиссын гишүүн Х.Мөнхзул, Д.Сүнжид, Б.Энхболд, Гадаад харилцааны яамны Олон улсын гэрээ, эрх зүйн газрын Хүний эрхийн хэлтсийн дарга Ц.Навчаа, “Оюутолгойн хяналт” Төрийн бус байгууллагын тэргүүн Д.Сүхгэрэл, “Хүний эрх хөгжил төв” Төрийн бус байгууллагын тэргүүн Г.Уранцоож, “Эмнести интернэшнл” Төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал Б.Алтантуяа.

Хууль санаачлагчийн илтгэл болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асуух Улсын Их Хурлын гишүүд байна уу?

Бусад танхимуудаас 7 гишүүнээр бусад танхимуудыг, Их хуралдай танхимыг 6 гишүүнээр тасаллаа. Нэрсийг дэс дараалалд оруулаад авчиръя.

Эрхэм гишүүн Лувсанцэрэнгийн Энх-Амгалан.

Л.Энх-Амгалан: Хууль санаачлагчаас асуух бас хэдэн зүйлүүд байна. Дэмжиж байгаа. Ер нь зарчмыг нь бол дэмжиж байгаа. Тэгээд манайх хүний эрх ноцтой зөрчигдөж байгаа улс орны нэг гэвэл мөн л дөө. Бид нар Үндсэн хуулиараа 18 хүний эрхийг тунхагласан, дагаж мөрдөх ёстой. Гэтэл Үндсэн хуулиар тунхаглагдсан 18 эрх нь нөгөө амьд явах эрхээсээ авахуулаад ингээд үргэлж зөрчигдөж байдаг. 18 эрх бүгдээрээ зөрчигдөж байгаа ийм улс орон байгаа юм. Тэгээд ер нь хаана хүний эрх ноцтой зөрчигддөг вэ гэхээр нэгдүгээрт дайн байлдаантай улсад, хоёрдугаарт нь дотооддоо шашны зөрчилдөөнтэй улсуудад, гуравдугаарт нь улс төрийн хатуу дэглэмтэй улс орнуудад хүний эрх зөрчигддөг гэсэн ийм судалгаа байдаг юм байна. Гэтэл бид нарт гурвуулаа байхгүй. Бид нар дотоодын дайн байлдаан байхгүй, шашны зөрчилдөөн байхгүй, улс төрийн хатуу дэглэм байхгүй. Тэгсэн мөртөө одоо бид нар ингээд жил бүхэн хамгийн наад захын жишээ гэхэд үйлдвэрлэлийн ослоор 200-гаад хүн амь насаа ард алддаг. Замын ослоор 500-600 орчим хүн амь насаа алддаг. Дайн байлдаантай улсуудаас илүү эрх нь зөрчигдөж, энэ хүмүүс эрүүл мэндээрээ амь насаараа хохирч байгаа ийм нөхцөлүүд байгаад байгаа юм.

Тэгэхээр дөнгөж саяхан одоо бид нар Хүний эрхийн Комиссын 5 гишүүнийг

нийтийн сонсгол хийж байгаад нийгмээс илүү оноо авсан гэж ойлгож байгаа, хүлээн зөвшөөрөгдсөн гэж ойлгож байна. Энэ 5 гишүүнийг томилоод явуулсан. Одоо тэгээд энэ хүний эрхийг хамгаалагч гэж тогтолцоо бий болоод дахиад ингээд хороо гарч ирнэ гэсэн нэг ийм зүйлүүд өнөөдөр байж байна. Тэгэхээр Хүний эрхийн комиссын өнгөрсөн хавар бид нар чинь бие даасан хуулийг нь баталсан. Хүний эрхийн Комиссыг нөгөө шүдгүй арслан байхад нь бид нар шүдтэй арслан болгож өгсөн гэж ойлгож байгаа юм. Гэтэл одоо яг энэ гарч ирж байгаа энэ хүний эрхийн хамгаалагчийн тодорхой хороо энэ Монгол даяар хийх гэж байгаа энэ тогтолцоо гэж яриад байгаа юм. Тэгэхээр үүнийг ер нь яг Монголын хөрсөнд ер нь яг яаж буулгая гэж одоо харж байгаа вэ? Хамгийн гол нь Монголын хөрсөнд буумаар байгаа юм л даа.

Г.Занданшатар: Хууль санаачлагч Дамдины Цогтбаатар.

Д.Цогтгэрэл: Энэ чухал асуултаа. Хүний эрхийн үндэсний комиссынхон яг энэ асуудал дээр энэ хуулийг боловсруулахад өөрсдөө маш идэвхтэй оролцсон. Эхлээд энэ асуудлыг надтай ярьж байхад би ч гэсэн яг энэ дээр -танай энэ ажил байж байгаа. Та нар энэ ажлынхаа хажуугаар энэ ямар ач холбогдолтой вэ гэдэг. Би бол бас өөрөө ийм шалгуур тавьж байж үүнийг хүлээж авч байсан. Тэгээд боловсруулах явцад энэ бусад орны нөгөө зөвлөхүүд, хүний эрхийн илтгэгч нартай ярьж байхад нэг юм их ойлгомжтой, ялангуяа Хүний эрхийн комиссынхон бас өөрсдөө энэ дээр нэмээд хариулах ёстой байх аа.

Хүний эрхийн комисс гээд бид нар нэг байгууллага байгуулчихаад. Эд нар чинь дандаа том юмнууд дээр яваад байгаа юм. Тэгтэл эд нарын хүрэхгүй байгаа саарал орон зай, эд нарт тэр болгон ирж мэдрэгдэхгүй байгаа энэ бас асуудлууд байгаа. Тийм ч учраас Хүний эрхийн комиссыг та нар ажлаа хийхгүй байна, энд ч хүрэхгүй байна, тэнд ч хүрэхгүй байна гэдэг асуудлууд явж байдаг. Өөрөөр хэлбэл энэ хүний эрхийн хороог байгуулснаар харин энэ хүний эрхийн комиссын үйл ажиллагааг нөгөө бодитой ажиллах нөхцөлийг нь бий болгож өгч энэ хүний эрхийн хамгаалагчдын хороо илүү энэтэй нөхөж ажиллах боломж гаргаж ирж байгаа юм, нэгд.

Хоёрт, Хүний эрхийн комисс дангаараа энэ ажлыг хийнэ гэхэд бол үнэхээр хүч нь хүрэлцэхгүй. Нийгэм өөрөө тэр чигээрээ ажиллах ёстой. Энэ хүний эрхийг хамгаалагчийн хуулийн төслийг та нар маань харах юм бол энэ дээр нөгөө хүний эрхийг хамгаалах үүрэг чинь бол зөвхөн төрийн байгууллагууд, шүүх прокурор, одоо бид нарын нөгөө хуучин сонгодог утгаар ярьдаг байсан байгууллага, нэгж институцууд биш. Бас төрийн бус байгууллагууд, компаниуд хүртэл энд ингээд ороод явж байгаа шүү гээд. Энэ дээр тэр үүргийг бас хүлээлгэж байгаа. Энх-Амгалан гишүүн маш зөв юм ярилаа. Сая тэр үйлдвэрлэлийн ослоор өдөр болгон ёстой нөгөө анзаарагдахгүй хүмүүсийн эрх зөрчигдөж байгаа байхгүй юу. Энэ судалгааг чинь тэр хүний эрхийг хамгаалагчид өөрсдөө судлаад үүнийгээ зоригтой.../хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Лувсанцэрэнгийн Энх-Амгалан гишүүн тодруулна.

Л.Энх-Амгалан: Энэ их л сэтгэл эмзэглүүлсэн судалгаа байна л даа. Ингээд хүний эрхийн төлөө тэмцэж байгаа хүний эрхийг хамгаалж одоо үг хэлж байгаа, үйл ажиллагаа явуулж байгаа хүмүүсийг бусдын халдлагад оруулдаг, дарамт шахалтад өртдөг, нэр төр, алдар хүндэд нь халддаг, сэтгэл санааны дарамт үзүүлдэг цахим хэлбэрээр доромжилдог. Ийм нөхцөл байдал өнөөдөр Монгол Улсад байна гээд ингээд судалгаагаар гараад ирчихсэн юм байна л даа. Тэгээд бодитой нөхцөл байдлууд сэтгүүлч нарт, өмгөөлөгч нарт, хуулийнханд.

Тэгэхээр яг энэ хууль батлагдаж гарснаар одоо ингээд яг энэ хүний эрхийг хамгаалагч нарын өнөөдөр үүсээд байсан энэ дарамт шахалт, энэ асуудлууд ер нь яаж цэгцрэх юм, яаж хамгаалагдах юм, ямар зохицуулалтууд байгаа юм.

Г.Занданшатар: Дамдины Цогтбаатар гишүүн хариулъя.

Д.Цогтбаатар: Яг одоо энд зориулсан л хууль гарч ирж байгаа. Юу гэвэл одоо та өөрөө бас эндээс харна биз. Энэ хүний эрхийг хамгаалах үүрэг бүгдэд нь байгаа юм. Тэгэхлээр аж ахуйн нэгж, байгууллагууд хүртэл одоо хөдөлмөрийн эрх зүй дээр хөдөлмөр хамгаалал дээр энэ эрхийг хамгаалах ёстой. Тэгээд үүгээр энэ хамгаалсан хууль өөрөө батлахаар нэгдүгээрт тэр хамгаалалт өөрөө энэ эрх зүйн хувьд норм болж институтчлэгдэж байгаа нэгд. Энэ ерөөсөө байгаагүй юм байна.

Хоёрт, нэгэнт хамгаалалт бий болчихсон байхад энэ асуудлаар асуудал тавиад миний одоо ар гэрт энэ дарамт шахалт үзүүлж байна гэхэд нөгөө байгууллагууд заавал хариу арга хэмжээ авах үүрэгтэй болчхож байгаа юм. Үл тоомсорлоод орхиод өнгөрөх боломжгүй. Үл тоомсорлоод харин өнгөрчихсөн байвал ийм хуулийн заалт байсаар байхад хохирол үүссэн байвал бусад хуулийн дагуу, мөн түүнчлэн нэмэх энэ хуулийн дагуу хүн хариуцлага хүлээж эхэлж байгаа юм. Тийм учраас энэ эрх зүйн хамгаалалтын тогтолцоо өөрөө институтчлэгдэж орж ирж байна гэдэг чинь өөрөө хамгаалалтыг бий болгож өгч байгаа юм.

Г.Занданшатар: Одоо Эзэн Чингис хааны танхимаас Ширнэнбандийн Адьшаа гишүүн.

Ш.Адьшаа: Энэ хуулийн төслийг зарчмын хувьд дэмжиж байгаа юм. Түрүүн би Байнгын хороон дээр ч ярьж байсан. Би асуулт асуухгүй, үг хэлчихье. Энэ хуулийн төсөл их оройтож гарч байгаа гэж ойлгож байгаа. Өнөөдөр хүний эрхийг хамгаалах, монгол хүн амьд явах, энэ Үндсэн хуулийн баталгааг хангах асуудал бол төр, хувийн хэвшил, ард иргэд, хүн бүхний үүрэг байх ёстой. Өнөөдөр Монголд хүний эрхийн зөрчил хамгийн их зөрчигддөг ийм улс орон гэдэгт олон нийтийн байгууллага, судлаачдын санал асуулгаар гарч ирсэн байгаа.

Хүний эрхийг хамгаалах энэ асуудал бол зөвхөн тэр хүний эрхийн комиссын 5 гишүүн, тэдний ажлын аппарат ажиллаад энд хүч хүрэлцэхгүй ээ, бодит амьдрал дээр. Тэгэхдээ энд хүмүүс хүний эрхийн хамгаалагчийн гэхээр нэр томьёоны хувьд эргэлзээд байх шиг байгаа юм. Энэ бол хуулийн олон улсын хэллэгээс авсан хууль эрх зүйн томьёолол байгаа. Тэгэхдээ энд гадаадад байгаа Монгол Улсын иргэд энэ үндэсний цөөнхийн асуудал, тэгээд энэ жендерийн

асуудал, энэ хэвлэл мэдээлэл, олон нийтийн сүлжээгээр хүний эрх зөрчигдөж байгаа энэ олон асуудлыг өнөөдөр Хүний эрхийн Үндэсний Комиссын энэ 5 хүн түүний аппарат хамгаална гэвэл өрөөсгөл болж байгаа юм. Энэ Хүний эрхийн Үндэсний Комиссийн энэ үйл ажиллагааг дэмжиж, олон нийтийн …/хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Адьшаа гишүүн 1 минут.

Ш.Адьшаа: Олон нийтийн үүсгэл санаачилгын байгууллага, нийгмийн хариуцлагын хүрээнд иргэний нийгмийн байгууллага, хувь хүмүүсийг хүний эрхийг хамгаалах, энэ боломжоор хангах асуудал бол өнөөдөр Монгол төрийн үүрэг, Монгол Улсын Их Хурлын үүрэг байх учраас энэ хуулийг нэн яаралтай баталж гаргаж, хүний эрхийг хамгаалах асуудалд Монголын төр, Монголын хууль тогтоох байгууллага дэвшил гаргана гэдэгт би эргэлзэхгүй байна.

Г.Занданшатар: Адьшаа гишүүн дэмжиж үг хэллээ.

Эрхэм гишүүн Нанзадын Наранбаатар Жанжин Сүхбаатарын танхимаас.

Н.Наранбаатар: Юуны өмнө бас энэ хуулийг дэмжиж байгаагаа хэлье. Хуулийн үзэл баримтлалтай холбогдуулан хэд хэдэн тодруулах зүйл байна. Нэгдүгээрт энэ хуулийн төсөлд хүний эрхийг хамгаалагч нь хэн байхыг тодорхойлж өгсөн. Үүн дотор эндээс харж байхад шүгэл үлээгч буюу аюулгүй байдлын эсрэг үйлдлийг илчлэгч мэдээлэгч бас орохоор юм шиг одоо ойлгогдож байна. Хэрвээ тийм бол энэ хуультай хамт хамтад нь, эрх зүйн байдлыг нь зохицуулсан байдлаар төсөлд тусгах уу, тусгахгүй юу? аль эсвэл одоо тусад хууль боловсруулж явж байгаа юу гэдэг талаар тодруулга тайлбар авъя.

Дараа нь энэ хүний эрхийг хамгаалагчийн эрх, төрийн байгууллага, албан тушаалтан, аж ахуйн нэгжийн нийтлэг үүргийг хуулийн төслөөр тусгасан боловч хүний эрхийн хамгаалагчийн хариуцлагын асуудал нь тодорхой бус байгаа. Хүний эрхийг хамгаалах нэрийн доор хувийн ашиг сонирхол хийдэг шантаажилдаг бас ийм үзэгдлүүд бас байдаг. Тэгэхээр үүнийг одоо яаж ялгаж салгах ёстой гэдгийг тодруулж өгөөч. Дээрээс нь одоо ийм хариуцлагагүй улсуудад үүрүүлэх хариуцлага нь Зөрчлийн хуулиар 100 мянган төгрөг гэдэг нь бол хэтэрхий бага байна гэсэн ийм санал байна.

Дараагийн асуудал, энэ дэд хороо байхаар тусгагдсан байна, хуулийн төсөлд. Хүний эрхийн комисст ажлын алба байгаа. Тэгээд ажлын албаны чиг үүрэг дотор энэ дэд хорооны чиг үүрэг тусгагдсан учраас давхцахгүй юу? Дэд хороо байгуулахаараа бас үйл ажиллагааны төсөв гэж байгаа. Тэгээд Хүний эрхийн үндэсний комисст энэ төсвийн суулгах болно. Ингээд төсвийн асуудал бас байгаа учраас энэ чиг үүргээ …/хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Дамдины Цогтбаатар гишүүн хууль санаачлагч асуултад хариулъя. Хүний эрхийн үндэсний комиссоос бас нэмж хариулахад бэлдэж байгаарай. Төсөв тооцоо, ажлын давхцалтай холбоотой асуудлуудаар.

Д.Цогтбаатар: Тэгэхлээр энэ дээр хүмүүс яг нэлээн нийтлэг андуураад байгаа юм бол шүгэл үлээгчийн асуудалтай хольж хутгаж андуураад байгаа юм. Энд бол хүний эрхийг хамгаалагчид яг хүний эрхийн чиглэлээр ажиллаад, хүний эрхийн чиглэлээр хүлээн зөвшөөрөгдөөд энэ асуудалд өөрийнхөө мэргэжил, мэдлэг мэргэшил энэ бүхнээ зориулчихсан энэ хүмүүсийн асуудал яригдаж байгаа юм.

Тэр хаа хамаагүй ингээд хүний эрхийг зөрчөөд явчихдаг, тэд өөрсдөө янз бүрийн гүтгэлэг хийдэг, төлбөртэй захиалгатай, хууль бус юмыг нэг их шударга дүртэйгээр ингээд хийгээд байгаа энэ улсууд бол энд орохгүй ээ. Харин ялгаж өгч байгаа юм. Энэ хууль дээр, бүр тодорхой өөрөө заагаад өгчихсөн байгаа. Хүний эрхийг хамгаалагч өөрөө хүний эрхийн хүрээнд л үйл ажиллагаагаа явуулна, түүнээс хүний эрхийг зөрчиж хүний эрхийг хамгаалахгүй ээ гээд.

Тэгэхлээр одоо юу гэдэг юм, ямар нэгэн хүн хүн гүтгэчихээд дараа нь асуудал гараад ирэхлээр -өө би энэ хүний эрхийг ингээд хамгаалж байгаа, намайг одоо энэ дээр ингээд оролдох гээд байна аа гэсэн ийм асуудал ярих харин эсрэгээрээ боломжгүй болчхож байгаа. Яагаад гэвэл хүний эрхийг зөрчиж ирчхээд, тэгээд хүний эрхийн хамгаалалт эрэлхийлээд энэ хуулийн шүхэр дор өөртөө хамгаалалт эрэлхийлнэ гэдэг бол энэ ойлголт байхгүй болж байгаа юм аа. Тэрүүгээрээ, энэ хууль бол ер нь энэ олон улсын түвшинд ч гэсэн энэ хүний эрхийг хамгаалагчид бол өөрсдөө энэ дээр огт өөр чиглэлийн яг тэр хүний эрх рүү чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг. Үүгээрээ ялгарч гарч ирж байгаа бас аягүй том эрх зүйн ахиц гэж би хараад байгаа юм.

Энэ дээр бол Хүний эрхийн комиссынхон чинь бол өөрөө энэ чинь 3 сая хүний эрхийн тухай асуудал яригдаж байгаа. Хүний эрхийн комисс бүгдээрээ энийг ингээд дангаараа, нээрээ бариад хийнэ гэвэл бол хүрэхгүй ээ. Угаасаа хүний эрхийг хамгаалагч, одоо тэр нийгмийн хамт олон гэе л дээ. Энэ бол хүний эрхийн комиссоос хамаагүй …/хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Сүнжид 87, Хүний эрхийн үндэсний комиссоос нэмээд хариулчих.

Д.Сүнжид: Чиг үүргийн хувьд хүний эрхийн үндэсний комиссын дэргэд хүний эрх хамгаалагчийн хороо гэж байгуулна гээд. Тэгээд хамгаалагчийн хороо нь өөрөө 7 гишүүний бүрэлдэхүүнтэй байхаар. Үүндээ Комиссын нэг гишүүн ахлаад, тэгээд цалингүйгээр энэ сайн дурын Монголын хуульчдын холбоо, Монголын өмгөөлөгчдийн холбооны төлөөлөл орж ирэх юм. Дахиад бас нээлттэй сонгон шалгаруулалтаар иргэний нийгмийн байгууллагаас 3 төлөөлөл орж ирэхээр төсөлд тусгасан. Тэгээд эдгээр гишүүд нь цалин хөлс байхгүй зардалгүйгээр ажиллахаар. Харин нэг хүн ажлын албан дээр буюу Хүний эрхийн үндэсний комисс дээр энэхүү ажлыг яг хариуцан зохион байгуулах, гардах нэг хүн байхаар тусгасан. Түүний зардал нь жилдээ 11 сая төгрөг юм байна лээ. Тэгээд материаллаг зардал гээд 21 сая. Ингээд жилдээ бол энэ хуулийг хэрэгжүүлбэл зардлын тооцоо 32 сая төгрөг гэдэг ийм тооцоо бол гарч байгаа.

Чиг үүрэгт энэ давхцлын хувьд Хүний эрхийн үндэсний комисс хуульд заасан чиг үүргээ хэрэгжүүлнэ. Түүнээс гадна энэ Хүний эрхийн хамгаалагчийн хорооны хоёр үндсэн чиг үүрэг байгаа. Нэгдүгээрт нь, хүний эрхийг хамгаалж байгаа хүмүүсийн бүлгийн эрх нь зөрчигдвөл энэхүү асуудал дээр эрсдэлийн үнэлгээ хийгээд тэгээд энэ хамгаалах асуудлыг хэрэгжүүлэх учиртай.

Хоёрдугаарт нь эрх мэдлийг нь цөөнх буюу одоо ялгаварлан гадуурхалтад өртсөн, эсвэл одоо эрхээ бүрэн утгаар нь хэрэгжүүлж чадахгүй байгаа, зөрчүүлж байгаа тэр хүмүүсийн тэр бүлгийн эрхийг бас авчирч энд дүгнэлт гаргаж өгөх үүрэгтэй. Ийм хоёр үндсэн чиг үүрэгтэй ажиллах ёстой юм.

Г.Занданшатар: Одоо Үндсэн хуулийн танхимаас Цэндийн Сандаг-Очир гишүүн.

Ц.Сандаг-Очир: Энэ хуулийг зарчмын хувьд дэмжиж байгаа гэдгээ Байнгын хороон дээр хэлсэн. Өнөөдөр үнэхээр л одоо манай улс орны нийгэмд хэрэгцээтэй байгаа энэ иргэний нийгмийн байгууллагуудын, эсвэл зарим нэг одоо улсуудын өдөөн турхиралт, хатгалгаар, дохиураар хөдөлдөг улс төрчдийг гэдэг юм уу, энэ хүний эрхийг хамгаалахын төлөө энэ нэрийн доор ингэж шүгэл үлээж авж байгаа улсуудыг яг үнэхээр хүний эрхийн төлөө тэмцэж байгаа хамгаалагчдыг ялгах энэ одоо эрх зүйн байдал баталгаажиж байгаа гэдэг үүднээсээ энэ хуулийн төслийг дэмжиж байгаа.

Нэг зүйлийг асууя. Хүний эрхийг хамгаалагчийн хороо, бас Байнгын хороон дээр яригдаж байсан. Хүний эрхийн комисстой үйл ажиллагаа, чиг үүргээрээ бас давхцаж байгаа асуудал байна. Манай эрхлэх асуудлын хүрээнд одоо мөн байна аа, биш байна аа гэдгийг хэрхэн яаж ялгах юм бэ? Хамгаалагчийг, энэ яг хүний эрхийн хамгаалагч мөн байна, биш байна гэдгийг хэрхэн яаж хамаарч одоо ялгаж энэ асуудал манай асуудал мөн байна гээд тэр хүний эрх зүйн асуудлыг хамгаалах асуудлыг яаж ялгаж салгах юм бэ гэдэг нь бас тодорхой бус байна аа.

Тийм учраас нөхдүүд өнөөдөр өргөдөл гомдол бариад миний эрх зүйг хамгаалж өгөөч ээ, би ингэж одоо асуудалд орж байна гэж яривал энэ одоо зөв байна, мөн байна, буруу байна гэдгийг ялгах, салгах нь одоо хэн дээр байх юм, хэн ялгаж салгах юм. Энэ асуудлыг нэг тодруулж өгөөч ээ гэж би асуух гэсэн юм.

Г.Занданшатар: Дамдины Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Энэ Хүний эрхийн хороонд шалгаруулах хүмүүс маань маш ил тод, нээлттэй, тэгээд энэ хүний эрх, ёстой бусад хуулиас нэг бас онцолж гарч ирж байгаа юм бол энэ жинхэнэ мерит зарчмыг энд угаасаа заагаад өгчихсөн байгаа. Олон улсын түвшинд хүлээн зөвшөөрөгдсөн илтгэл, хуралд оролцохдоо бичиж байсан, хүний эрхийн чиглэлээр дагнан ажиллаж байсан ийм хүмүүс хороонд орж ирнэ. Энэ хүмүүс Хүний эрхийн Үндэсний Комисстой хамтраад ажиллахдаа ерөөсөө л хүний эрхийн асуудлаар байгаа бүх асуудлуудыг эд нар судална. Судлаад хүний эрхийн комисстоо өөрсдөө зөвлөмж өгөөд, эд нартайгаа

хамтарч ажиллана. Гар нь хүрээгүй газар нэмж судалгаа хийж өгнө. Байгаа асуудлуудыг тодруулж гаргаж ирэх ийм одоо ажлуудыг хийх юм.

Энэ хүний эрхийн асуудал, энэ өргөн хүрээтэй юмыг комисс дангаараа биш, тэртэй тэргүй хүний эрхийг хамгаалагчидтай л нийлж энэ асуудлуудыг гарна уу гэхээс бол энэ одоо улс орныг хамарсан бүх юмыг энэ 5 гишүүн бол гаргахгүй.

Тийм учраас тэр хүний эрхийг хамгаалагчид гэж байж байгаа. Яаж тодорхойлох вэ гэхээр, угаасаа л хүний эрхийн асуудал өөрөө их тодорхой цар хүрээтэй. Одоо сансрын асуудал биш. Жишээлбэл хөдөлмөр эрхлэх асуудал дээр байх уу? Боловсролын асуудал дээр байх уу, нийгмийн асуудал дээр байх уу. Яг хүнтэй холбогдсон хүний эрхийн тэр түгээмэл эрх зүйн нормуудтай холбогдсон асуудлууд дээр. Одоо жишээлбэл Эрүүгийн хууль дээр үнэхээр одоо давж болохгүй босгыг хэн нэгэн даргын одоо захиалгаар очоод даваад тэр хүмүүсийн эрх ашгийг хөндөөд байгаа бол яг үүнийг л тэр хүмүүс гаргаж ирнэ.

Үүнийг дарга нар дээр сууж байгаа хүмүүс бол тэр болгон олж харахгүй. Түүнийг чинь яг тэр газар дээрээ тулж ажиллаж байгаа хүмүүс л энэ жижиг зөрчлүүдийг гаргаж ирнэ. Нэг жижиг зөрчлийн цаана маш олон зөрчил явж байгаа гэсэн үг. Тэгэхлээр энэ зөрчлүүдийг энэ нүх сүвийг л хааж өгөх ажлыг энэ хорооныхон хийх юм.

Г.Занданшатар: Тэр чиг үүргийн давхцал байна уу гэж асуугаад байсан. Цогтбаатар гишүүн.

Д.Цогтбаатар: Чиг үүргийн давхцал гэхээсээ угаасаа хүний эрх гэдэг бол хаана ч хүний л эрх. Хүний эрхийн комиссынхны хийж байгаа ажил ч хүний эрх, эд нарынх ч хүний эрх. Зөвхөн эд нар нэг нэгнийгээ нөхөж ажиллах, хүний эрхийн комисстойгоо хамтарч ажиллах, одоо эд нар өөрсдөө бүр жишээтэй ярьдаг юм. Бидний ингээд гар хөл хүрэхгүй байгаа энэ энэ сегментүүдийг очоод судлаад эд нар гаргаад ирэх боломжтой, тэнд асуудлыг нь судлаад гаргаад ирэх боломжтой, засах тэр саналуудаа гаргаад ирэх боломжтой л гэдгийг ярьж байгаа юм.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Одонгийн Цогтгэрэл Их засаг танхимаас.

О.Цогтгэрэл: Баярлалаа. Энэ хүний эрхийг хамгаалагчийн тухай, ер нь хүний эрхийн эрх зүйн байдлыг дээшлүүлэх тухай энэ маш чухал. Хуулийг зарчмын хувьд нь дэмжиж байгаа юм. Тэгэхдээ үзэл баримтлал хэсэгт бас нэг тодруулах зүйл байна. Ер нь бид нар хүн төрөлхтний нийтлэг хөгжлийн замаар төр гэдэг чинь үүсмэл юмаа, иргэн нь төрөө байгуулдаг, төр нь иргэндээ үйлчилдэг гэдэг энэ замыг сонгоод ямар ч байсан ил тод зарлаад гучин жил явлаа, тодорхой үр дүнд хүрсэн. Тэгэхдээ бас эргээд хүний эрх нь хангагдахгүй тохиолдлууд их байгаа учраас ард иргэдэд бас их эргэлзээ, тэр тусмаа энэ бүр томоороо ардчилалд эргэлзэх эргэлзээ хүртэл бас байгаа юм шиг боддог.

Тэгэхээр энэ миний хувь хүний дүгнэлтээр бид нар ардчилалд асар том

алхам, ахиц үр дүнд хүрсэн. Тэгэхдээ бид нарын өнгөрсөн хугацааны гучин жилийн ардчилал нэг их тийм элитийн ардчилал, иргэний ардчилал биш элитийн, ардчилал, даргын ардчилал, төрийн ардчилал тал руугаа бид нар явчихсан байх. Ийм учраас тэр иргэн нь төрөө байгуулдаг. Хүний эрх, иргэний эрх гэдэг ойлголтууд маань бид нарын хувьд бүдгэрч энэ тал руу томоохон алхам, бодлого чиглэл явуулах ёстой юм шиг. Тэгэхээр эндээс бас гол нь энэ үзэл баримтлалтай холбоотой юу гэж хэлэх гээд байна вэ гэхээр, энэ хүний эрхийг хамгаалагч гэдэг чинь дахиад томоороо үр дүнд хүрэхийн тулд хэсэг бусаг хүмүүс бусдынхаа эрхийг хамгаалдаг тухай ойлголт бас байж болох юм.

Тэгэхдээ хамгийн том чухал асуудал нь иргэн бүр өөрийнхөө эрхийг хамгаалагч байхын тулд бид нар бодлого чиглэл, хууль дүрэм энэ чиглэлд яг юу хийх ёстой юм бэ? Иргэн бүр өөрийнхөө эрхийг хамгаалагч, үндсэндээ бид нар, иргэн төрөө байгуулдаг, бид нараас үүсмэл юм гэчхээд бид нар одоог хүртэл иргэн өөрийнхөө эрхийг мэдэхгүй, хувь хүн өөрийнхөө яг үнэндээ эрхийг мэдэхгүй ийм байр байдал маш их байдаг.

Г.Занданшатар: Хууль зүйн байнгын хорооны дарга Сандагийн Бямбацогт.

С.Бямбацогт: Цогтгэрэл гишүүний хөндөж байгаа асуудал их чухал асуудал байгаа юм. Тэгэхээр хуулийн төслийн үзэл баримтлалыг харвал үндсэндээ Хүний эрхийн үндэсний комисстой чиг үүргийн хувьд бас давхцах юм шиг, ажлаа бас булаацалдах юм шиг тиймэрхүү ойлголт бас төрөхөөр байгаад байгаа юм. Тэгэхээр Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэх эсэхийг дэмжигдвэл Байнгын хорооноос ажлын хэсэг байгуулъя. Ажлын хэсэг байгуулаад Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуультайгаа уялдуулах, давхцлыг нь арилгах, хоорондоо бие биеэ дэмжиж ажиллах энэ бололцоо, боломжийг бүрдүүлэх тал дээр зайлшгүй ажлын хэсэг байгуулж ажиллах шаардлага байгаа. Сая ярьж байгаа тэр элитийн ардчилал гэдэг юм уу, даргын ардчилал гэвэл ярьж байгаад анхаарах ёстой. Хамгийн их одоо орхигдож байгаа асуудал үнэхээр хэн эрх мэдэлтэй байна, хэн мөнгө төгрөгтэй байна, хэн илүү хэл амтай нь бусдын эрхийг зөрчдөг ийм асуудал байгаад байгаа юм. Тэгвэл тэр хэл амтайд нь дээрэлхүүлж байгаа, тэр даргад нь, эрх мэдэлтэйд нь дээрэлхүүлж байгаа мөнгөтэй, төгрөгтэйд нь дээрэлхүүлж байгаа тэр иргэдийн эрх ашгийг хангах тал дээр илүү анхаарч болох ийм цоорхой байгаа. Энэ рүү одоо Хүний эрхийн үндэсний комиссын хуулийг шинэчилж, Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагааг өргөжүүлж, бүрэн эрх нь нэмэгдсэн.

Яг үүнтэй холбоотойгоор Хүний эрхийн үндэсний комиссын дэргэд энэ хүний эрхийг хамгаалагч хороо ажиллаж, энүүгээр хүний эрхийг хангах тал дээр илүү бас илүү сайн ажиллахын тулд энэ хуулийг 2018 оноос хойш ярьсан юм байна. 2018 оноос очиж ярьж судлаад, одоо энэ 2020 онд эцэст нь орж ирж байгаа. Тийм болохоор батлахын хувьд бид бас дэмжээд явчих нь зөв байх.

Ингэхдээ бид нар илүү давхцалгүй хийдэлгүй одоо яг орхигдоод байгаа тэр тийм үү, яг ядарсан зүдэрсэн тэр иргэдийнхээ эрхийг хангуулах тал руу нь илүү яаж чиглүүлэх вэ гэдэг дээр Байнгын хорооноос ажлын хэсэг байгуулж, Хүний

эрхийн үндэсний комиссын тухай хуультай уялдуулах, давхцуулахгүй байх. Одоо энэ дээр орчихсон байж байгаа зөвлөмж гаргана, дүгнэлт гаргана гээд.

Г.Занданшатар: Одонгийн Цогтэрэл гишүүн тодруулна нэг минут.

О.Цогтгэрэл: Тэгээд түрүүнийхээ, бас гүйцээгээд ярихад. Тийм учраас иргэн нь өөрөө өөрийнхөө эрхийг хамгаалагч байх чиглэлд энэ хуулийн чинь үзэл санаа илүү чиглэвэл, тэгвэл тэр иргэний боловсрол руу яаж анхаарах юм. Энэ чиглэл рүү бол үзэл санааны хувьд, бас энэ хууль маань чиглэх ёстой юм биш үү? Зүйрлээд хэлэх юм бол бид нар биеийн тамирт хандахдаа олимпын аваргууд төрөхөөр биеийн тамир хөгжиж байгаа юм шиг бид нар ойлгодог бол нийтийн биеийн тамир гэдэг зүйл чинь өөрөө ард иргэдэд илүү чухал зүйл байдаг. Тэгэхлээр яг зүйрлээд хэлбэл энэ жишгээр энэ хуулийн үзэл санаанд хандвал яасан юм бэ? Хэн нэгэн хүнд хамгаалахаасаа урьдаар иргэдийн боловсролыг дээшлүүлэх чиглэлд энэ хуульдаа бас нэг зүйл заалтыг илүү тусгаасай л гэж бодож байна.

Г.Занданшатар: Хүний эрхийн боловсролын асуудал ярьж байна. Дамдины Цогтбаатар гишүүн хуулийн үзэл баримтлалд энэ талаар яаж тусгагдсан бэ?

Д.Цогтбаатар: Энэ хуулийн яг цаад агуулга үүнийг ярьж байгаа юм. Хүний эрхийг тэр хамгаалах ажил гэдэг бол өргөн бүх нийтийн асуудал шүү, зөвхөн цөөн хүний биш. Харин энэ хууль бас нэг юмыг хүлээн зөвшөөрөөд байгаа юм. Хүний эрхийн төлөө өөрийнхөө эрх чөлөөг зольж яриад байдаг хүмүүс чинь цөөнх нь юм байна. Тэр цөөхөн хүнийг чимээгүй болгочихлоор цаана нь бүгдээрээ өөрөө хүний эрхээ уг нь эдлэх ёстой хүмүүс нь эдлэхгүй, харин хохироод явчих тохиолдол маш их байдаг юм байна. Хүний эрхийн ерөнхий нөхцөл байдлаас аваад үзвэл энэ дэлхий дээр нээрээ Нельсон Мандела гэдэг нэг хүн байсан учраас өмнөд Африкт апартейд гэдэг бүхэл бүтэн тогтолцоо өөрчлөгдөж байгаа. Мартин Лютер Кинг гэж нэг хүн байсан учраас тэр арьс өнгөөр ялгаварлах үзэл бодол нийгэмд өөрчлөгдөж байгаа, тэрний дараа тэр нэг хүн дуугарч байсан учраас дараа нь тэр нийгэм тэр чигээрээ нөгөө хүний эрхийн боловсрол, тэр тогтолцоо чинь бүр өргөжөөд бүгдээрээ мэддэг болчихсон, бүгдээрээ эрхээ хамгаалдаг болчихсон.

Тэгэхлээр тэр хүний эрхийн нийгмийн боловсролыг бий болгоход энэ хэдхэн дуугарч байдаг хүмүүс чинь хамгаалалттай байх хэрэгтэй, тэд нарын ар гэр хамгаалалттай байх хэрэгтэй. Яг үүнийг л зориод байгаа нь цаанаа эргээд хүн болгон тэр эрхийг чинь эдлэх, тэрийгээ мэддэг болох тэр боломж суурийг нь л тавьж өгч байгаа юм.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Одонтуяа гишүүн асуулт асууна.

С.Одонтуяа: Хуулийн төслийн үзэл баримтлал, шаардлага, үндэслэл бүх зүйлтэй сайн танилцлаа. Тэгээд агуулгын хувьд бол дэмжиж байна. Мэдээж дотор нь нэмэлт өөрчлөлтүүд, янз бүрийн саналуудыг тусгаад явахад болох байх аа. Тэгээд ер нь зөвхөн Монгол Улсад биш, энэ дэлхий дахинд энэ хүний эрхийн төлөө тэмцэгчдийг хэрхэн хамгаалах гэдэг энэ өөрөө их чухал асуудал. Ялангуяа

ардчилал бага хөгжсөн ийм улс орнуудад бол энэ их хэцүү асуудал. Тэгэхээр манайд хамгийн дутагдаад байгаа юм нь бол механизм байгаа. Одоо хэн нэгэн эрх нь зөрчигдөхөд яг хэнд хандах вэ гэдгээ мэддэггүй. Өөрөөр хэлбэл өмгөөлөгчид хандах уу, эсвэл нэг дарга дээр очихоор сонсдоггүй. Тэгэхээр энэ яг хэнд хандах вэ гэдгийг нарийн тусгаж өгсөн үү? Жишээлэхэд, гадаадад байгаа монголчууд сая ковидын үеэр эрх нь маш их зөрчигдсөн. Ингээд бидний эрх ингэж зөрчигдөөд байна гээд наашаа хандаад байдаг, үүнийг нь хүлээж авах хүн байдаггүй. Бид нар иргэний онцгой комисс гээд өдөрт л хэдэн мянган захидлуудад нь ингээд хариулт өгөөд ядаж нэг тайвшруулаад Онцгой комисст үүнийг нь өгөхөд, эргээд энэ нь өөрөө хуулийн этгээд биш учраас бид нар энэ асуудлыг бол Онцгой комисс хүлээж авах боломжгүй гэдэг.

Тэгэхээр хувь хүн яаж хандах юм бэ, хэнд хандах юм бэ? Ялангуяа энэ онцгой байдлын үед хүний эрх зөрчигдвөл хэнд хандах юм бэ гэдэг заалтууд туссан уу?

Хоёрдугаарт иргэдийн энэ амьдрах орчин бол маш их эрх нь зөрчигддөг. Одоо ингээд дүүрэг дээр байж байтал дүүрэг нь мэдээгүй, иргэд нь мэдээгүй байтал ингээд цонхыг нь хаагаад ингээд байшин бариад байдаг. Тэгээд нөгөө иргэд нь хэнд хандахаа мэддэггүй. Дүүрэг нь өгөөгүй байдаг. Нийслэлийн гадаа очоод чадлаараа хэдэн хүн нь очоод л жагсаал хийдэг, тэгээд ямар ч үр дүн байхгүй. Тэгэхээр ийм тохиолдолд ер нь одоо бас ингээд хэнд хандах юм бэ гээд. Ингээд олон асуудлууд гарч байгаа юм л даа. Тэгэхээр энэ механизмтай болж байгаа юм байна гэдэгт бол би их баярлаж байна. Тэгээд ялангуяа одоо энд ингээд нэг улс төрчид дуугарахлаар улс төржлөө гэнэ. Эсвэл энд бас байна шүү дээ. Голдуу сөрөг хүчин гэж харж хардаг учраас их алдаа гардаг гэж. Тийм учраас энэ зүйлийг тусгах юм байна. Энд баяртай байна.

Одоо би хүүхдийн хамгааллын хууль, хүүхдийн эрхийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах гэж байгаа. Энэ дээр хамгийн чухал асуудал юу вэ гэхээр хүүхдийн эрхийн төлөө байцаагч, улсын байцаагч гэсэн нэр томьёог бас урьд нь оруулж байсан юм. Гэтэл энэ бол замхарсан. Яагаад гэхээр сая байцаагч нартай уулзахад төрийн албан хаагч, тэгээд хавсарч хийдэг юм байна. Маш их ажилтай. Тэгэхээр нөгөө төрийн албан хаагч чинь төрийнхөө эсрэг ингээд дуугараад байж чаддаггүй. Тэгэхээр энэ өөрчлөлтөөр над дээр хамтарч ажиллаж өгөөрэй. Хуулийн концепц дээр гэж хэлмээр байна.

Тэгээд ер нь зоригтой мэдээлэл хийдэг, энэ ард иргэдийнхээ төлөө зоригтой дуугардаг хүмүүсийг монголчууд хүсээд байгаа юм шүү дээ. Ялангуяа одоо мэдээлэл бол их чухал байдаг. Одоо ковидын үед бол ерөөсөө …/хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Дамдины Цогтбаатар гишүүн. Сая нэг минут шууд нэмээд өгчихсөн шүү.

Д.Цогтбаатар: Яг одоо ингээд иргэд хаашаа хандахаа мэддэггүй ээ. Тэгээд ганцхан энэ улс орон даяар болж байгаа юмнуудыг хүний эрхийн комисст

хандаад түүнд нь хүргээд, түүнд нь Хүний эрхийн комисс нь өөрөө бүгдийг нь хүрээд энд нь хариулаад явна гэдэг бас тийм амар биш.

Тэгэхлээр эд нарын тэр ажлыг нөхөж ажиллана, хамтарч ажиллана гээд байгаа чинь тэр нөхөөд хийгээд өгч байх. Тэгээд нөгөө олон нийтэд хүний эрхийн чиглэлээр ажиллаад танигдчихсан хүлээн зөвшөөрөгдчихсөн. Түүнээс гэнэт юу ч хүний эрхийн талаар юм хийдэггүй байж байснаа би мэднэ гээд ороод ирж байгаа их мэдэгч биш. Энэ хүмүүсээр энэ асуудлуудыг нэгтгүүлэх судлуулаад гаргаад энэ дээр ийм одоо шийдэл байна аа, боломж байна аа гээд Хүний эрхийн комисст хандаад, түүний хажуугаар бусад байгууллагууд руугаа бас хандаад хамтраад ажиллах тэр боломжтой энэ нэгжийг л энд гаргаж өгч байгаа юм, нэгд.

Хоёрт, яг таны хэлсэн энэ зоригтой дуугардаг хамгаалаагүй байхад яаж зоригтой дуугарах вэ? Ард нь очоод гэр бүлийг нь оролдоод эхлэхэд яаж зоригтой дуугарах вэ? Энэ хүний эрхийг хамгаалж байгаа хүмүүс гэдэг чинь хэн нэгний төлөө, дандаа эрх мэдэлтэй хүмүүсийн хууль бусаар хуулийг тойрч гарч бусдын эрхийг зөрчөөд байгаа юмыг л гаргаж ирж ярих хүмүүс шүү дээ. Тэгэхлээр тэд нарыг зоригтой байлгая гэж байгаа бол, энэ эрх зүйн нөхцөлийг нь өөрөө бүрдүүлж өгөхгүй бол энэ байхгүй байгаа хамгааллыг бий болгож өгөхгүй бол нээрээ болохгүй юм байна билээ. Тэгээд аль ч хүнээс очоод л -өө чи ингээд хийхгүй байна гээд загнаад байхаар, харин түүний оронд бид нар бол хууль тогтоогчид, энэ ажиллах нөхцөлийг чинь бүрдүүлээд өгчихлөө. Одоо харин ажлын үр дүнгээ нэхээд сууж байхад илүү бас дөхүү болж байгаа гэж бодож байгаа. Жишээлбэл та хууль гаргахад одоо эд нар чинь тус болох боломжтой байгаа юм. Эд нарын ажил байгаа юм. Та одоо хүүхдийн эрх дээр ийм, ийм, ийм асуудал гараад байна аа.

Г.Занданшатар: Одоо Эзэн Чингис хааны танхимаас Балжиннямын Баярсайхан гишүүн асуулт асууна.

Б.Баярсайхан: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Монгол Улсад хүчирхийлэл их байгаа энэ цаг үед хүний эрх хамгаалагч гэсэн нэр томьёотой ийм хууль санаачлан батлах гэж байгаад талархаж байна. Дэмжиж байна. Гэхдээ энэ асуудлыг хоёр талаас нь авч үзэж, тодорхой сайн зохицуулалт хийж, ойлголтыг нэг мөр болгох хэрэгтэй. Учир нь нэг талаас хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажилладаг хувь хүн, байгууллагын эрх ашгийг хамгаалах тэдний эрх зүйн орчин бүрдэж байгаа сайн талтай хэдий ч, нөгөө талдаа хүний эрх хамгаалагч нэрээр бусдын эрхийг зөрчдөг, гутаан доромжилдог өөр ашиг сонирхлоор ажилладаг хэсэг бүлэг бий болох вий гэсэн бас болгоомжлол байна.

Ингэхгүйн тулд энэ хуулийн зохицуулалт маш нарийн, тодорхой, ойлгомжтой, олон талаас нь тусгасан, хүний эрх хамгаалагчийг жинхэнэ утгаараа ажиллах нөхцөл нөхцөл боломжийг бүрдүүлсэн эрх зүйн орчин байгаасай гэж хүсэж байна.

Надад 2 асуулт байна. Хүний эрхийг хамгаалах хороо нь Хүний эрхийн үндэсний комиссын дэргэд хараат бусаар бие даасан байна гэсэн байна. Энэ

хүний эрхийг хамгаалах хороо ямар эрх мэдэл, эрх хэмжээ, чадвар, чадамжтай байх юм бэ? Энэ талаар хуульд тодорхой тусгаагүй байна. Цагдаа, шүүхийн байгууллага хүний эрхийн эсрэг үйлдэл хийж байгаа бол энэ хороо ямар хариу үйлдэл үзүүлэх эрхтэй вэ? Цагдаа, шүүх гэлтгүй одоо сошиалаар хүртэл хүний эрх зөрчиж байгаа үйлдлийг таслан зогсоох ямар эрх мэдэл тэдэнд байна вэ? Хүний эрх зөрчигчдөд энэ хорооны сануулга хариу үйлдэлд зогсох, тэдний үгийг сонсох шаардлагыг биелүүлэх ямар хөшүүрэг байна вэ гэж асуумаар байна.

Хоёр дахь асуулт болохоор нэлээн олон хуульд энэ хүний эрх хамгаалагчийн үр нөлөө, оролцоог зааж зохицуулсан заалт оруулах шаардлага гарч ирж байна гэж ойлгож байна. Хуулиудад энэ чиглэлийн нэмэлт өөрчлөлтүүд орох уу? Тухайлбал Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль байна. Хөдөлмөрийн хууль, Байцаан шийтгэх хууль, Зөрчлийн тухай хууль гэх мэт.

Г.Занданшатар: Баярсайхан гишүүн нэг минут.

Б.Баярсайхан: Тэгэхээр энэ хуулийн зохицуулалтад хүний эрх яригддаг, хүний эрх зөрчигддөг. Сая бас олон гишүүд энэ талаар ярьж байна. Тэгэхлээр энэ болгон дээр хүний эрх хамгаалагч тэдний эрхийг хамгаалж дуу хоолой болж байгаа хөндлөнгийн хяналт болох энэ хүмүүсийн ажиллах орчин нөхцөлийг илүү сайжруулахын тулд энэ дээрх хуулиудад нэмэлт өөрчлөлтүүд орох шаардлагатай гэж харж байна. Энэ хоёр асуултад хариу авъя. Баярлалаа.

Г.Занданшатар: Дамдины Цогтбаатар гишүүн хууль санаачлагч. Ажлын хэсгээс нэмж хариулж болно.

Д.Цогтбаатар: Их тодорхой хэлээд байгаа юм нь хүний эрхийг гутаан доромжилчхоод хүний эрхийг хамгаалж байна гэж ярихгүй. Өөрөөр хэлбэл хүний эрхийг энэ хуулийн хүрээнд хамгаалдаг хүмүүс бүр их тодорхой заагаад өгчихсөн байгаа юм. Хүний эрхийг хуулийн хүрээнд, олон улсын хүний эрхийн хууль эрх зүйн тогтолцооны хүрээнд, тэр хэм хэмжээний хүрээнд хамгаалж байж сая хүний эрхийг хамгаалж байгаа юм. Энэ хуулийн ерөөсөө үзэл агуулга нь тэр. Түүнээс аливаа нэгэн гутгэн доромжилчихсон юм нь хийчхээд, би энд одоо ийм сайн хүн, одоо намайг ингээд хамгаалаад өг өө гэсэн тийм юм байхгүй. Харин эсрэгээрээ тэд нарыг ялгаж гаргаж өгч байгаа ийм хууль шүү. Тэгэхгүй бол энэ янз бүрийн үнэн худал, одоо бодит чин сэтгэлээсээ ажиллаагүй, өөрийн эрх ашиг, явцуу эрх ашиг, албан тушаалын тэр карьерын хүсэл сонирхолтой улсууд баахан шоу хийчхээд, тэгээд дараа нь хүний эрхийг хамгаалах энэ ариун үйлс өөрөө тэд нарын доор нэр хүнд нь гутаагдаад яваад байгаа энэ юманд бас таслан зогсоох боломжийг ялгаж салгаснаараа гаргаж ирж байгаа юм.

Хороо бие даасан байна гэдэг нь эд нар, судалгаагаа хийгээд өөрсдөө энэ хүмүүс. Хүний эрхийг хамгаалж байгаа хүмүүс бол өнөөдөр энэ хороотой, хороогүй бор зүрхээрээ судалгаагаа хийгээд, шүүмжлэх юмаа шүүмжлээд өөрсдөө ажиллаад явж байгаа юм. Тэд нарт энэ хамгааллыг нь өгвөл илүү урамтай, илүү зоригтой ажиллах боломж гарч өгнө. Тэгээд шүүх, цагдаагийн энэ үйл ажиллагааг таслан зогсоох гэдэг дээр шүүх процесс эд нарт хажуугаас орж

ирж таслан зогсоох нөлөөлөх ойлголт бол байхгүй шүү дээ. Өнөөдөр хүний эрхийн тогтолцоо юу вэ гэхээр тэр хүний эрхийг хамгаалах тогтолцоо байсаар байтал, түүнийг мэдсээр байж хууль хэрэгжүүлэх байгууллагынхан хэрэв тэрийг тойроод хүний эрхийг зөрчөөд, тэр хүн тэр үйлдлээрээ хүний эрхийн хууль тогтоомжийг нөгөө хүн зөрчөөд байгаа юм.

Г.Занданшатар: Энэ хариултад 1 минут гэж байхгүй. 88, Хүний эрхийн үндэсний комиссоос хариулна гэсэн.

Б.Энхболд: Та бүхэнд өдрийн мэнд хүргэе. Нэгдүгээрт тэр хүний эрхийн хамгаалагчийг бусад хүний эрхийн нэр барьж олон нийтийн дунд буруу мэдээлэл өгөөд байдаг хүмүүсээс хэрхэн ялгах вэ гэдэг асуудал дээр яг ийм дөрвөн зарчим байгаа юм. Тухайн асуудал нь хүний эрхийн асуудал байх ёстой, хоёрдугаарт нь нийгмийн сайн сайхан, тодорхой хүний эрх ашгийг хамгаалахад чиглэгдэнэ, гуравдугаарт нь тэр үйл ажиллагаа нь хууль зөрчөөгүй, бусдыг уриалан турхираагүй хүч хэрэглэх ийм хэв шинжгүй байна, дөрөвдүгээрт нь туушгай байх ёстой гэдэг ийм 4 зарчмыг яг баримталж, хүний эрхийн төлөө явж байгаа бол энэ хүний эрхийг хамгаалагч байна гэж үзэхээр байгаа юм.

Гэтэл одоогийн бодит нөхцөл байдалд зорилго нь биелэгдмэгц тухайн асуудлыг ярихаа больчихдог нь тэр хүн туушгай биш байна. Энэ бол хүний эрхийн хамгаалагч гэхэд эргэлзээ төрж байгаа ийм асуудал байгаа учраас энэ дөрвөн зарчмаараа ялгана гэж үзэж байгаа юм.

Хороо комисстой чиг үүргийн хувьд ямар давхцал байж болох вэ гэхээр энэ хороо бол дэмжих чиг үүрэгтэй байгаа юм. Өнөөдөр Хүний эрхийн үндэсний комисс дээр төрөл бүрийн гомдол ирж байна. Энэ гомдлын дагуу бид нар арга хэмжээ авахын тулд тогтоосон байх ёстой болоод байдаг. Гэтэл энэ хүний эрхийн хамгаалагч бол тодорхой баримтаа гаргаад, юмыг тогтоогоод, тэрний төлөө тэмцсэнийхээ төлөө одоо аюулгүй байдал, бусад нөхцөл байдал нь эрсдэлд орчихсон ийм хүмүүс хороонд хандана. Хороо бол энэ үнэхээр хүний эрхийн асуудал байсан юм байна гэдгийг тогтоогоод өгөх юм бол комисс энэ асуудлыг бариад, цаашид холбогдох байгууллагууд руу нь анхаарал хандуулж явдгаараа энэ нэгнийгээ дэмжих уялдах ийм зохицуулалт байгаа юм гэдгийг тайлбарлая. Баярлалаа.

Г.Занданшатар: Одоо Жамъянхорлоогийн Сүхбаатар гишүүн.

Ж.Сүхбаатар: Баярлалаа. Би гол санаануудаа Байнгын хороон дээр хэлчихсэн. Энэ удаад ганц л юмыг төсөл санаачлагчид хэлье гэх үү, захья гэх үү. Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдал гээд ингээд ийм хууль хийчихсэн. Хүний эрх хамгаалагч гэдэг нэрийг аваад тодорхойлчихсон байгаа юм. Тэгээд үүнээсээ бас болгоомжлоорой. Энэ юм чинь их өргөн байна аа гээд би санаагаа хэлээд байна шүү дээ. Тэгэхээр энэ нэрээ жаахан өөрчилбөл яасан юм бэ. Хүний эрх хамгаалагч гээд. Тэгсэн хэрнээ тэгээд тэр нь болохоор тодорхойлолт нь маш өргөн. Бараг хүн болгон хүний эрх хамгаалагч юм шиг. Ингээд өөрөө тавьчихдаг. Яг хүний эрх хамгаалах комиссарууд гэж ярих юм бол манай Хүний эрхийн

үндэсний комиссын гишүүд л хүний эрх хамгаалагчид байгаа шүү дээ. Тэгэхээр энэ нэр томьёогоо бодоорой. Их том нэр томьёо, томдчихсон л гарчиг болчхоод байгаа юм шүү. Би үүнийг л хэлэх гэсэн юм. Тэгээд үзэл баримтлалын хувьд ингээд дэмжээд явж болж байна. Цогтбаатар гишүүний хэлээд байгаа нөхөн гүйцээх, туслан дэмжих тэр орон зай дээр ажиллая хэлж байгаа зохицуулалтыг нь ажилд үнэхээр хэрэгтэй гээд байгаа бол дэмжихэд бол болохгүй юмгүй гэж бодож байгаа юм.

Гол нь та бүхэн маань энэ хуулийнхаа тэр агуулгыг харвал тэр гарчиг чинь бол арай л том байгаад байгаа шүү л гэж хэлэх гэсэн юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Санал юм даа, Сүхбаатар гишүүн ээ. Одоо Лхагвын Мөнхбаатар гишүүн.

Л.Мөнхбаатар: Хуулийн төслийг дэмжиж байгаа. Энэ хуулийг баталж гаргах бас практик шаардлага манайд байна. Хүний эрхийг хамгаалах чиглэлээр ажиллаж байгаа хувь хүмүүс, төрийн бус байгууллага, хуульч нар гээд олон хүмүүс байгаа юм. Гэхдээ энэ үйл ажиллагаа нь хуульчлагдаагүй учраас одоо өөрсдөө буруутгагдах, тодорхой дүрэм журам зөрчсөнд тооцогдох. Түүнчлэн өөрт хамааралгүй зүйлд хошуу дүрлээ гэх мэтчилэнгийн ингээд олон саад бэрхшээлүүд байдаг. Ийм учраас бол төрийн хувьд энэ эдгээр сайн дураараа хүний эрхийн төлөө, хүсэл зоргоороо ингээд тэмцэж байгаа энэ хүмүүсийн эрх зүйн байдлыг хуульчилж өгөх нь зүйтэй.

Нөгөө талаар олон улсын байгууллагууд ч үүнийг бас зөвлөдөг. Ер нь хүний эрх хамгаалагчийн загвар хууль гээд байдаг юм. Одоо энэ чинь 2015-16 онд нэг томоохон хурал болсон шүү дээ. Хүний эрхийн бүс нутгийн бүх төлөөллүүд оролцсон, 500-600-аад хүон оролцсон. Эндээс загвар хууль гэж гаргасан л даа. Энэ загвар хуулийн гол зохицуулалтууд одоо энэ хуульд орсон уу? Загвар хуулийн. Ер нь бол хүний эрх гэдэг маань бол нийтлэг дэлхийн асуудал шүү дээ. Тийм учраас энэ үндэсний онцлог гэхээсээ илүү энэ нийтлэг зүйлүүдийг бол энэ загвар хуулиасаа аваад оруулсан байгаа болов уу гэж би бодож байна. Энэ бол бүгд хуульчлагдаж чадсан уу гэдгийг асууя.

Хоёрдугаарт нь энэ хүний эрхийг хамгаалагчийн эрхийг нь бас зөрчдөг хамгийн гол субъектууд бол төрийн байгууллагууд, дээр нь бас энэ хууль сахиулах байгууллагууд байдаг л даа. Ийм учраас эдгээр хүний эрхийг хамгаалагчдаа хамгаалах арга механизмыг нь одоо яг төрийн байгууллагууд бас гэсэн үг шүү дээ. Тийм ээ. Тодорхой хүмүүсээс гадна. Төрийн байгууллагуудаас хамгаалах энэ механизмуудыг нь хэрхэн яаж тусгасан бэ гэдгийг асууя.

Нөгөөтээгүүр энэ хүний эрхийн хамгаалагч гэдгийг хэрхэн таних вэ гэдэг асуудал байгаа юм. Түрүүн бас хэд хэдэн гишүүд бас хөндөж ярьж байна.

Г.Занданшатар: Мөнхбаатар гишүүн нэг минут.

Л.Мөнхбаатар: Хүний эрхийг хамгаалагч бол хувь хүн ч байж болно,

ашгийн бус одоо байгууллага ч бас байж болно л доо. Тодорхой мэргэжил туршлага бол одоо тавьдаггүй ийм зүйл шүү дээ. Тэгэхээр энэ хүний эрхийг хамгаалах зорилгоор ажиллаж байгаа энэ хүмүүсийгээ хүний эрх хамгаалагч болохыг нь одоо эргэн яаж баталгаажуулах вэ? Одоо нэг компани, аж ахуйн нэгж хүний эрхийг зөрчиж байна, энд гаргасан дүрэм журам зөрчиж байна гээд хүний эрхийг хамгаалъя гээд яваад очиход одоо тэрийгээ хэрхэн яаж одоо баталгаажуулж, хүлээн зөвшөөрөгдөх вэ гэдэг асуудал байгаа юм. Мөн нөгөөтэйгүүр бас энэ өөрсдийнхөө хувийн эрх ашигт, хэрвээ энэ хүний эрх хамгаалагч гэдэг энэ статусыг хэрэглээд ирсэн бол ямар хариуцлага хүлээлгэх вэ гэдгийг бас хэлж өгөөч ээ гэдгийг хэлье.

Дараагийнх нь бол энэ шүгэл үлээгч гээд одоо энэ хүний эрхийг хамгаалагч нарын нэг төрөл л дөө. Хүний эрхийг хамгаалах чухал механизм байдаг. Өмнө нь 2012-16 оны парламентын үед байх Шүүмжлэгчийн эрхийг хамгаалах тухай хууль гэж орж ирээд, буцсан. Одоо энэ Шүгэл хамгаалагчийн тухай энэ хууль.../хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Цогтбаатар гишүүн хариулъя.

Д.Цогтбаатар: Энэ НҮБ-ын загварын хуулийг бид нар хууль боловсруулах явцдаа хэрэглэсэн. Ер нь НҮБ-ын Ерөнхий ассамблейн тогтоолтой. Хүний эрхийг хамгаалагчийг хамгаалах тухай НҮБ-ын Ерөнхий ассамблейгаас гарсан тогтоол бий. Үүний хажуугаар манайх энэ дээр бид нар нэлээн удаан ажилласан. Энд олон бас хурлуудыг, төрийн бус байгууллагуудтай хүний эрхийг хамгаалдаг энэ хүмүүстэйгээ хамтарч бол хийсэн. Хэд, хэд хийсэн. Түүний хажуугаар хүний эрхийн асуудлаарх тусгай илтгэгч гарч, манайд ирж энэ хууль дээр зөвлөгөө өгч оролцоод, сүүлдээ энэ дээр манайхыг нэлээн дэмжиж ажилласан. Энэ бол зөв санаачилга, зөв хууль явж байна гээд. Хүний эрхийн дээд комиссариатын газраас дэмжсэн. Тэгэхлээр энэ загвар хуулийн үзэл санаа бол манай энэ хуулийн төсөлд бол суусан байгаа.

Төрийн албан хаагчийн үүргийн тухайд энэ хуулийн гуравдугаар бүлэгт бүр ингээд тодорхой заачихсан байж байгаа юм. Энэ төрийн хүний эрхийг хамгаалагчийн асуудал гараад ирэхэд үүнийг анхаарахгүй, үл тоомсорлоод орхиод өнгөрч болохгүй шүү. Энэ дээр арга хэмжээ авах ёстой. Тэр ар гэрт нь ямар нэгэн хамгаалалт хэрэгтэй байгаа бол үүнийг үзүүлэх ёстой. Үүнийг үзүүлээгүй байж байгаа сөрөг үр дагавар гарвал энэ хуулийнхаа дагуу ч, бусад хуулийн дагуу ч, өөрөөр хэлбэл бусад хуулийн дагуу ч хариуцлага хүлээх байлаа гэхэд энэ дээр тэр хариуцлагын хэмжээ өшөө нэмэгдэж өгч байгаагаараа тэр хамгаалал өөрөө бэхжиж байгаа гэсэн үг.

Шүгэл үлээгчийн энэ бол асуудал биш ээ. Энэ яг хүний эрхийг хамгаалж байгаа. Сая бид нар энэ талаар тодруулж, Хүний эрхийн үндэсний комиссоос энэ дээр ярьж байна. Яг тодорхой шалгууруудаар ийм, ийм хүмүүс л энэ хуульд одоо хамрагдаж энэ хуулийн хамгаалалд орно гэдгийг нь ялгаад салгаад заагаад өгчихсөн байж байгаа юм. Тэгээд сая ярьж байна. Мэдээж хуулийг боловсруулах явцдаа ажлын хэсэг байгуулагдаад энэ дээр байгаа юмнуудыг өшөө

боловсронгуй болгоод явах боломж Их Хурлынхаа түвшинд хамтарч ажиллаад өшөө сайжруулаад гаргах боломж бий гэж бодож байгаа.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Мөнхөөгийн Оюунчимэг.

М.Оюунчимэг: Баярлалаа. Манай улс 1992 онд баталсан Үндсэн хуульдаа бүр тодорхой заавал 19.1-д төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болоод бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна гээд бүр тунхаглаад заачихсан байгаа л даа. Тэгээд харамсалтай нь дааанч энэ нэн чухал заалт хаа сайгүй бол зөрчигдөх болсон. Сүүлийн жилүүдэд бол бүр ч дэндүү зөрчигдөж, эцэстээ хүний эрхийн төлөө нэг бүлэглэл, одоо хүмүүсээ хамгаалсныхаа төлөө дуугарсан хүмүүс амь насаа алдах, түрүүн хэлж байна, нэр усанд нь халдах гээд маш ноцтой зөрчлүүд бол их гарах болсон л доо.

Магадгүй тиймээс ч гэсэн НҮБ-аас хүний эрхийн эрхийн эрхийг хамгаалдаг хүмүүсээ хамгаалах хуулиа Монгол Улсын парламент гаргах шаардлагатай байна аа гэсэн зөвлөмж хүртэл хүргүүлсэн байсан. Нийгмийн бодлогын байнгын хороон дээр ч энэ асуудлууд яригдсан л даа. Тэгээд би нэг зүйлийг бүр нэн чухал хэлмээр байна л даа. Бид Зндсэн хуульдаа ингээд маш онцгойлон чухалчлаад заагаад өгчихсөн хэрнээ өнөөдөр Монголын төрд хүний эрхийг хамгаалах нэгдсэн бодлого байхгүй байгаад байна аа. Үнэхээр дутагдаад байна. Би сая одоо дурсан бодож байна л даа. Одоо хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийн хөрөнгө санхүүжилт буруу зам руу яваад байна гэдгийг баримттай юутай нь гаргаж тавьж, цуврал нийтлэл бичиж энэнийхээ төлөө тэмцэж яваад ямар ч хамгаалалтгүй байж байгаад Өнөөдөр сонины сэтгүүлч Болормаа маань нас барж, амь насаа алдсан байгаа. Тэр ирвэс хамгаалагч залуу яаж тэмцэж байлаа, дараа нь амь насаа алдсан тохиолдол гарсан. Ажлын байран дахь хүчирхийлэл, дарамт одоо янз бүрийн дарамтаас болоод хэнд ч хандаж чадахгүй байж байгаад нэг сайхан залуу, хоёр хүүхдийн ээж бас амь насаа алдсан гээд яриад байвал зөндөө байна л даа.

Энэ нь өөрөө юу яриад байна гэхээр Монгол улс хүний эрхийг хамгаалах энэ асуудал дээрээ үнэхээр онцгойлон анхаарах цаг болжээ гэдгийн жишээ яваад байгаа. Гэтэл энэ ингээд парламент дамжаад л хэлэлцэгдэхгүй ирээд байдаг.

Г.Занданшатар: Оюунчимэг гишүүнд нэг минут өгье.

М.Оюунчимэг: Тэгэхээр цаг нь болсон гэдэг дээр хүлээн зөвшөөрч байна. Хамгийн гол нь харин сая хэлж байна, цалингүй ажиллана ч гэх шиг. Ер нь энэ хүний эрхийг хамгаалагчаа дуугарч байгаа үүний төлөө, ингээд бүр ажлаа цагаа амьдралаа зориулаад дэмжиж байгаа хүмүүс магадгүй цалинтай хүртэл ажиллавал урамшуулалтай ажиллавал энэ чинь үр дүнд хүрнэ шүү дээ. Бусад улс оронтой адилхан. Тэгэхээр миний түрүүн хэлээд байгаа төр нэгдсэн бодлоготой болгох суурь энэ хуулийг гаргаснаар үндэс суурь нь тавигдах уу үгүй юу үүнийг хамгаалж чадах уу, эсвэл бүр бүхэл бүтэн интитут ер нь цаашдаа энэ дээр хүн хүч, хүний нөөц, санхүүжилт, бүх нэгдсэн бодлого хэрэгтэй гэдгийг энэ хуулиараа бид зааж өгөх ёстой юу? Энэ дээр бас нэг тодорхой хариулт авъя аа гэж бодож

байна. Баярлалаа.

Г.Занданшатар: Цогтбаатар гишүүн хууль санаачлагч.

Д.Цогтбаатар: Энэ хүний эрхийн төлөө ингээд бор зүрхээрээ явж байгаа хэдийгээ дэмжих ёстой. Төсвийн асуудал дээр нь, бид аль болох хэмнэх тал дээрээ л боловсруулаад энэ Хүний эрхийн комиссынхоо дэргэд авчирч хийж байгаа нь бол аль болох энэ бааз суурин дээрээ л юм хийчих гээд нөгөө хэмнэх сэтгэлгээгээрээ ажиллаж байгаа нь үнэн. Их Хурал дээр ажлын хэсэг маань ажиллах явцдаа энэ дээр хэрэв өөр зоригтой алхмууд хийх ёстой гэвэл би бол сэтгэлээсээ дэмжинэ. Хүний эрхийг хамгаалж байгаа хүмүүс маань ч энэ дээр бол баярлах байх гэж бодож байна.

Хүний эрхийг хамгаалахад нэгж ихчухал юм. Үнэхээр энэ өөрөө хамгаална гэдэг институц нь ингээд хамгаалагдах юм уу гээд асууж байна. Их сонин. Ерөөсөө хүний эрх хамгаалагдсан байгаа шүү дээ Монгол улсад. Тунхаглалаараа бол их гоё. Бүх юм нь байж байгаа. Тэгээд бүгдээрээ адилхан хамгаалалттай байгаа. Гэхдээ энд сууж байгаа бүх хүн мэдэж байгаа шүү дээ. Хүний эрх зөрчигдөөд байгаа. Энгийн иргэдийн эрх бол тэр үл тоомсорлол хүнд суртлаар дамжуулж хэчнээн их зөрчигдөж байгааг би одоо нотолж ярих гээд хэрэггүй.

Хамгаалал нь байгаад байгаа мөртөө зөрчигдөөд байна шүү дээ. Тэгэхлээр энэ дээр нөгөө хамгаалагчид бол бүр үүнээс хүнд ажил. Нөгөө тэр зөрчигдөж байгаа хүмүүсийг чинь очоод өмөөрөөд, тэр эрх мэдэлтэй хүмүүстэй чинь ажиллаад байх болохлоор ердийн тэр хамгаалалтаас гадна тэр ажлаа хийх боломжийг нь олгож өгч нэмэлт тэр хамгаалалтын шинэ институцийг эрх зүйн хувьд норм болгож бид нар гаргаж ирэхгүй бол бусадтай адилхан эрхтэй байж чи яагаад ажиллахгүй байгаа юм гээд 3 сая хүнээ шахаад байх ойлголт байхгүй байгаад байгаа юм.

Тийм учраас энэ хамгаалал өөрөө бий болж байгаа нь тэр хамгааллыг бий болгож байгаа. Одоо энэ хуульд заачихсан заалтуудаас чинь бас төрийн эрх мэдэлтнүүд хаашаа ч зайлж чадахгүй шүү дээ. Үүрэг болгоод хийгээд өгчихсөн байж байгаа.

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Хаянгаагийн Болорчулуун.

Х.Болорчулуун: Баярлалаа. Манай улс ардчилсан нийгэм байгуулаад 30 жил болж байна. Тэгэхэд Монгол Улсад хүний эрх, эрх зөрчигдөж байгаа талаар нь сая гишүүд ярьж байлаа. Хүний эрх зөрчигдөх битгий хэл энэ хүний эрхийн төлөө цогтой тэмцэгч хүмүүсийг хамгаалах тухай хууль гараагүй, дөнгөж одоо орж ирж байна. Энэ оройтож гарч ирнэ гэсэн үг л дээ. Ер нь хүний эрхийн төлөө бол ажилладаг, тэмцдэг хүмүүс бол хувийн эрх ашгаа хойш нь тавьсан, цаанаасаа шударга, тийм хүмүүжил гентэй ийм хүмүүс байдаг л даа. Нийгмийн манлайлагч. Бид бүхэн мэдэж байгаа. Олон улсын хэмжээнд тэр сая Цогтбаатарын хэлдэг Нельсон Мандела, Мартин Лютер Кинг авахуулаад арьс өнгөний төлөө цогтой тэмцэгч. Клара Цеткин гэж эмэгтэйчүүдийн эрх ашгийн төлөө бид 3 сарын 8-нд

тэмцсэнийх нь төлөө тэмдэглэдэг. Энэ хүмүүс бол өөрсдийн бүр одоо эрх ашиг, амь насаа золиослон байж, байж хүний эрхийн төлөө тэмцэж амжилтад хүрсэн. Тийм хүмүүс ч Монголд байгаа гэдэгт эргэлзэхгүй байгаа. Олон олон хүмүүс дуу хоолойгоо өргөж дуугардаг яг тийм хүний төлөө явдаг, ажилладаг хүмүүсийн эрх зүйн байдлыг хамгаалах ийм хууль бол маш чухал.

Хэдий тэгэхдээ хууль гарсан ч гэсэн яг энэ Хүний эрхийн төлөө үндэсний комисс бол бас яг тийм шударга зан чанартай, хүмүүжилтэй ийм хүмүүс байх нь юу юунаас чухал л даа. Сая бол 5 гишүүн олон нийтийн хэлэлцүүлгээр сонгогдсон гэж байна. Би та бүхнийг бол тийм хүмүүс байгаа гэж бас итгэж байна аа. Олон түмэнд чинь итгэж итгэлээ өгсөн. Ер нь тэгээд хүний эрхийн төлөө тэмцэнэ гэдэг амьдралын, нийгмийн харилцааны өргөн салбарт нь ажилладаг хүмүүсийг хөдөлмөрийн аюулгүй нөхцөлд амьдрах.../Хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Болорчулуун гишүүн нэг минут.

Х.Болорчулуун: Тэгээд та бүхнээс асууя. Энэ хуулийг гаргахад олон улсын ямар одоо хууль туршлагуудаас санаа авч энэ хуульдаа шигтгэсэн бэ? Мэдээж ардчиллын замаар хөгжсөн энэ улсууд бол хүний эрх, хүний өмчийг дээдэлж байж ардчиллаа дээдэлсэн улс орон гэж яригддаг. Үүний талаар хэлээч. Түүнээс гадна Хүний эрхийн үндэсний комисс чинь Улсын Их Хурлын харьяа байгууллага болчихлоо. Дандаа цалин хөлсгүй ажиллахгүй ээ, цалин хөлстэй ардаа санаа зовохгүй байж хүний төлөө сайн ажиллана. Тийм учраас энэ цалин хөлс, хангамжийн асуудлыг цаашдаа нь яаж шийдвэрлэх талаар нь хууль дээр тусгасан заасан юм байна уу. Энэ талаар хариулж өгөөч.

Г.Занданшатар: Цогтбаатар гишүүн хууль санаачлагч.

Д.Цогтбаатар: Үнэн. Одоо яг энэ дээр бид нар олон улсын туршлагыг нэлээн авч, олон улсын бас зөвлөхүүдтэй ч их ажилласан. Би нөгөө түрүүн хэлсэн. Энэ асуудлаар яг одоо хүний эрхийн тусгай илтгэгч, хатагтай Лолар Монголд ирж ажиллаад, энэ дээр энэ одоо хууль их зөв хууль болно. Үүнийг та нар гаргаарай, бид нар дэмжинэ гэдэг энэ асуудлуудыг ярьж байгаа. Энэ нь одоо хууль батлагдаад ирэхэд Монголын хүний эрхийн институцийг бүхэлд нь энэ дэмжих тэр дэмжлэг олон улсын түвшинд өөрөө явах, суурь нь тавигдах ийм боломжтой юм. Өнөөдрийн байдлаар дэлхийн дөчөөд орон өөрийнхөө хуульд тодорхой түвшинд, энэ хүний эрхийг хамгаалагчдын хууль эрх зүйн нормыг бол хуульчлаад батлаад өгчихсөн байгаад байгаа. Тэгэхлээр энд бусад орнуудын жишиг НҮБ-ын түрүүн ярьдаг тэр загвар хууль дээр суурилж өөрөө боловсруулагдаж, энэ батлагдсан байгаа.

Төсвийн тухайд гэвэл би сая хэллээ дээ, одоо ажлын хэсэг байгуулагдаад боловсруулах явцдаа, нэр томьёон дээр болон мөн боловсронгуй болгох юмнууд байгаа байгаа. Тэгээд тэрийг Улсын Их Хурлынхаа түвшинд хэдүүлээ яриад сайжруулж болно. Төсөв дээр бид нар бол 32 саяыг л тавьсан байгаа. Бид юунаас болгоомжилсон гэхлээр, одоо ийм хямралтай жилд ийм их мөнгө тавиад ороод ирлээ гээд л бас шүүмжлүүлнэ гэж болгоомжлоод аль болох хэмнэх сэтгэлгээгээр

одоо энэ дээрээ хандсан байгаа. Гэхдээ энэ дээр бас төсөв дээр нь бодож үзэх ёстой гэж ярих юм бол би л хувьдаа дэмжинэ.

Г.Занданшатар: Болорчулуун гишүүн.

Х.Болорчулуун: Хүний төлөө явж байгаад, хүний эрхийг хамгаалж байгаад өөрөө хэлмэгдсэн хүмүүс бол гадаад, дотоодод бишгүй байдаг аа. Хамгийн том олон нийтийн мэдэх жишээ бол эрх мэдэлтнүүдийн эсрэг хүнийг өмгөөлж хамгаалж байгаад тэр Тагнуулын газрын дарга Баатарыг өмгөөлж хамгаалж байгаад шоронд орсон Санжаасүрэн гэж хүнийг бүгд мэдэж байгаа байх. Яг Санжаасүрэн шиг ийм хүний эрхийн төлөө хүнийг өмгөөлж байгаад шоронд орсон, ийм хэлмэгдсэн хүмүүс ямархуу байдаг юм байна, тоо хэмжээ судалгаа байдаг уу? Энэ хууль гарснаараа бол одоо ийм байдал үүсэхгүй гэсэн баталгаа болж байна гэж ойлгож болно биз дээ? Тийм ээ.

Д.Цогтбаатар: 83 Мөнхзул.

Х.Мөнхзул: Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Энэ хүний эрхийн хэлмэгдсэн, энэ хүний эрхийн хамгаалагчдын энэ асуудлын бас талаар тоо баримт байна уу гэж байна. Тэгээд энэ дээр бол яг энэ хуулийг бид нар одоо баталснаар хүний эрхийн хамгаалагч гэж хэн юм бэ? Хүний эрхийн хамгаалагч нь одоо бусад төрлийн энэ хүний эрхийн төлөө шударга бусаар тэмцэж байгаа хүний эрхийг хүндэтгэхгүй тэмцэж байгаа энэ хүмүүсээс юугаараа ялгаатай юм бэ? Үүнийг энэ Хүний эрхийн хамгаалагчийн хороо энэ дээр гаргаж ирнэ.

Түүнээс гадна энэ хуулийг баталснаар энэ хүний эрхийн хамгаалагчийг бид нар жинхэнэ халдлагад өртсөн асуудлыг нь бүртгэлжүүлж статистик тоог нь гаргаж, ингэж тэдний хамгаалагчийн эрхийг хамгаалах аюулгүй.../хугацаа дуусав/

Г.Занданшатар: 84. Гадаад харилцааны яам олон улсын туршлага гэсэн.

Ц.Навчаа: Та бүхний энэ өдрийн амгаланг айлтгая. Түрүүн асуусан асуултад нэмэлт хариулт мэдээлэл өгье. Энэ хуулийн төслийг боловсруулахад гадаадын ямар олон улсын байгууллагатай харьцаж ажиллав гэсэн асуулт байсан. Хуулийн төслийг боловсруулахдаа НҮБ-ын хүний эрхийн дээд комиссарын алба, мөн тусгай илтгэгч нар болоод европын аюулгүй байдал хамтын ажиллагааны байгууллагын хүний эрхийн алба зэрэг энэ байгууллагуудтай зөвлөлдөж ажилласан байгаа.

НҮБ-ын хүний эрхийн хамгаалагчдын асуудал хариуцсан тусгай илтгэгч 2019 оны 4 сард Монгол Улсад ажиллаад гаргасан тайландаа хүний эрхийг хамгаалагчдын үйл ажиллагааг хөхүүлэн дэмждэг, тэдэнд боломж олгодог, бүрэн эрхийг нь эдлүүлдэг таатай орчин бүрдээгүй байна. Тийм учраас энэ хүний эрхийг хамгаалагчдын эрх зүйн байдлыг баталгаажуулахад чиглэсэн хууль гаргахыг зөвлөж байна гэсэн. Энэ зөвлөмжийг эдгээр олон улсын байгууллагын байгууллага болоод тусгай илтгэгчдээс өгсөн зөвлөмж, мөн НҮБ-ын хүний эрхийг

хамгаалагчдын загвар.../хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Эрхэм гишүүн Бадмаанямбуугийн Бат-Эрдэнэ.

Б.Бат-Эрдэнэ: Баярлалаа. Энэ хуулийн төслийг бол дэмжиж байгаа, Цогтбаатар гишүүн ээ, дэмжиж байгаа. Би энэ Хүний эрхийн комиссынхноос нэг зүйл асуух гээд байна. Тэгээд бид нар бол яг өнөөдөр ингээд тоо баримттай гарч байгаа хүний эрх зөрчигдөж байгаа, эрдэнэт хүний амь нас үрэгдэж байгаа гээд ярих юм бол олон асуудлыг ярьж болно. Бүх хүрээнд одоо гарч байгаа хүчирхийлэлтэй холбоотой асуудлыг ярьж болно. Тэгэхээр зэрэг энэ дандаа үйл явдлын муу үр дагаврыудтай нь бид ноцолдоод байгаа юм л даа. Энэ цаад талынх нь учир шалтгаан хаана байгаа юм?

Бид Үндсэн хуулиараа тунхагласан хүнлэг энэрэнгүй ийм нийгмийг байгуулна гээд 30 жилийн өмнө л тунхагласан. 30 жил гэлдрээд одоо ийм хэмжээнд хүрчхээд байгаа юм. Энд одоо та бүхэн маань сууриар нь одоо ямар үнэлэлт дүгнэлт өгч байгаа юм бэ? Дандаа мундаг чадалтай та бүхнийг томилогдож байхад бид бүгд л дэмжээд саналаа өгөөд л гаргасанй. Сайн мэргэжлийн олон газар одоо ажиллаж байсан, сургууль соёлыг нь төгсгөсөн ийм хуульч хүмсүүд байна. Тэгэхээр зэрэг бид нар зэрэгцүүлээд одоо бий болчихсон байгаа энэ хүнд бэрх байдлаас гарахын тулд хууль эрх зүйн шаардлагатай зохицуулалтыг нь хийх хэрэгтэй. Арга хэмжээнүүдийг дэс дараалалтай авах ёстой.

Зэрэгцүүлээд үндсэн шалтгаан, суурь нөхцөл нь одоо юу байгаа юм бэ? Түүнийг нь бид нар дүн шинжилгээ хийж үзээд тэндээс нь эхэлж засах ажлыг бид нар давхар хиймээр байна шүү дээ. Дэлхийн бусад улс орнууд чинь энэ рүү анхаараад.../хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Бат-Эрдэнэ гишүүнд нэмэлт минут. Таны Хүмүүнлэгийн боловсролын хууль чинь бас энэ хүний эрхийн боловсролтой уялдах юм байна шүү дээ.

Б.Бат-Эрдэнэ: Тэгээд ийм зүйлийг л би хэлээд байгаа юм. Одоо та бүхэн маань харж байгаа биз. Бид нараас огт өөр барууны шашин соёл, үзэл ухамсартай ийм улс орны орнууд, дорно дахины улс орнуудын энэ чинь хоорондоо хүчээ нэгтгээд ямар нэгэн одоо шашнаас ангид ёс суртахууны боловсролын тухай асуудлыг маш хүчтэй дэлхий нийтээрээ тавьж байна шүү дээ. Тэгэхээр бид нар одоо юмны араас нь явж болмооргүй байна л даа. Тэгэхээр бид нар үүнийг нь одоо зэрэгцүүлээд авч үзэх хэрэгтэй байна. Их Хурлын удирдлагууд, Засгийн газрын Ерөнхий сайдын тавьж байгаа нийгмийн соён гэгээрэлтэй холбоотой. Энэ ёс зүй, ухамсрыг дээшлүүлэх, ёс суртахууныг сайжруулахтай холбоотой том зорилт, бодлогын хүрээнд бид нар хүмүүнлэг боловсролыг дэмжих тухай хуулийн төсөл өргөн барьчихсан.

Г.Занданшатар: Дугарын Сүнжид хариулъя, 87.

Д.Сүнжид: Бат-Эрдэнэ гишүүний асуултад хариулъя. Энэ урьдчилан

сэргийлэх арга хэмжээ бол үнэхээр чухал. Тэгэхээр Хүний эрхийн үндэсний комиссын хийх ёстой нэг арга хэмжээ нь бодлогын баримт бичиг, хуулийн төслүүдэд хүний эрхийн талаас нь үнэлэлт дүгнэлт өгөх учиртай, нэгдүгээрт.

Хоёрдугаарт нь хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж өөрөө давхардал хийдэл зөрчилгүй буюу хүний эрхийн талаас асуудалгүй механизмыг тусгаж чадсан байна уу үгүй юу, хамгаалж хангаж үнэхээр чадаж байна уу гэдэг дээр дүн шинжлэлтэй хийгээд, хэрвээ засах, залруулах зүйл байх аваас түүнд нь бас санал өгөх учиртай. Нэг урьдчилан сэргийлэх механизм, арга зам нь энэ мөн. Хоёрдугаарт нь эрх зүйн аливаа боловсрол, ерөнхий боловсрол, мэргэжлийн боловсролын түвшинд хүний эрхийн хандлага суурилсан мэдлэг мэдээлэл, боловсрол өгөх хөтөлбөрийг байнга үргэлжлүүлж, тогтмол системтэйгээр үргэлжлүүлэх асуудал үнэхээр чухал байгаа. Энэ нь зөвхөн ерөнхий боловсролын сургууль төдийгүй хууль сахиулах чиглэлийн мэргэжилтнүүд бэлтгэдэг Дотоод хэргийн их сургууль, одоо алба хашиж буй төрийн албан хаагчид, тэгээд иргэний нийгмийн байгууллагууд гэзд бүх түвшиндээ ялгамжтай энэ эрх зүйн боловсрол, хүний эрхийн боловсролыг олгох асуудал чухал байгаа.

Одоо ирж байгаа өргөдөл, гомдол дээр дүн шинжилгээ хийгээд үнэхээр эрх зөрчилтэй бол шууд асуудалд нь хариу арга хэмжээ авах үүрэгтэй. Ингээд хамгийн их зөрчигддөг асуудал дээр цаашид ямар байдлаар урьдчилан сэргийлэх боломжтой вэ гэдгийг нь бодлогын түвшинд, хууль тогтоомжийн түвшинд, бас боловсролын түвшинд болоод хэрэгжилтийн түвшинд нь сууриар нь арга хэмжээ авах ёстой гэдэгтэй санал нийлж байна. Жилдээ бол Хүний эрхийн үндэсний комисст 600-700 орчим гомдол ирдэг юм байна. Гомдлоос энэ хөл хорионы үетэй холбоогүй үед бол хамгийн их зөрчигддөг эрх нь хөдөлмөрлөх эрхтэй шууд холбогддог. Хөдөлмөрлөх эрх нь олон янз байна. Зөрчигдөж байгаа хэлбэрүүд нь. Гэвч хамгийн их болохгүй байна аа, системийн хувьд авч үзэх ёстой гэж хэлээд байгаа нь төрийн болон хувийн хэвшлийн албан хаагч, ажилтнуудын дунд ажил олгогчдын дунд энэ хөдөлмөр эрх зөрчиж байна уу?

Г.Занданшатар: Одоо эрхэм гишүүн Төмөрбаатарын Аюурсайхан асуулт асууна.

Т.Аюурсайхан: Энэ бол хүний эрхийг хамгаалж байгаа энэ зохицуулалтыг хийж байгаа хууль биш ээ. Үүнийг бас гишүүд анзаарч байгаа байх аа. Нэр нь энэ тулгамдсан асуудлыг их тусгасан учраас хүмүүс бас дэмжсэн хандлагаар ярьж байгаа байх. Тэгээд энэ Засгийн газрын хуралдааны тэмдэглэл байна л даа. Хуулийн төслийг хэлэлцээд энэ бол их олон хууль тогтоомжтой зөрчилдөж байна. Хүний эрхийн тулгамдаж байгаа асуудлуудыг яг тусгасан, шийдсэн асуудлууд байхгүй байна. Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай, Эрүүгийн, Зөрчлийн, Гэрч, хохирогчийг хамгаалах, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай, Монгол улсын шүүхийн тухай, Прокурорын тухай, Хүүхдийн эрхийн тухай хуулийн заалтуудтай зөрчилдөж давхцаж, үүгээрээ бас хийдэл үүсгэж байгаа ийм асуудлыг хөндсөн байна шүү дээ. Олон улсын конвенцын зорилтуудыг хүчин төгөлдөр хууль тогтоомж дээрээ тусгаж ингээд шийдэх боломжтой гэж тэмдэглэл дээр тусгасан байна. Би үүнтэй санал нэг байгаа. Тэгээд энэ хуулийн төсөл дээр

яг гол асуудлаасаа хазайсан асуудлууд зөндөө л байна.

Тэгээд та бүхэн, жишээлбэл хүний эрх хамгаалагч бол мөн шүү дээ, Үндэсний комиссын гишүүд бол тодорхойлолтоороо. Тэгээд жишээлбэл та бүхнийг болон гэр бүлийн гишүүн, хамтран амьдрагчийг гүтгэж болохгүй, залилж болохгүй, хуурч мэхэлж болохгүй, үйл ажиллагааг нь дэмжихгүй байж болохгүй гээд энэ асуудлууд чинь Монгол Улсын ямар ч иргэнийг одоо ингэж болохгүй гээд л хууль тогтоомжоороо зохицуулчихсан байгаа шүү дээ. Тэгээд үүнийг заавал одоо ингэж давхар зохицуулах ямар шаардлага байна.

Одоо бид хүртэл та нарыг томилж байгаа этгээдүүд одоо үйл ажиллагааг чинь шүүмжилж болохгүй, ийм асуудал хуульд чинь тусчихсан байгаа юм. Гэтэл Хүний эрхийн үндэсний комисс одоо өөрийнхөө хуульдаа өөрчлөлт хийж болно шүү дээ. Тэгээд одоо яагаад ийм зохицуулалтууд хийж байгаа юм. Яагаад шүүмжилж болдоггүй юм, та нарыг. Унтаа өнөөдрийг хүртэл ажилласан чинь үнэн шүү дээ. Ажлаа хийж чадахгүй байгаа чинь үнэн. Бүх хуулийн боломж чинь байна. Хүний эрхийг Үндсэн хуулиасаа эхлээд бүх хууль тогтоомжид маш тодорхой заагаад өгчихсөн байгаа.

Нэг минутаа авъя. Үүнийг удаа дараа хэлж байгаа.

Г.Занданшатар: Аюурсайхан гишүүнд нэмэлт нэг минут.

Т.Аюурсайхан: Удаа дараа хэлж байгаа. Гол асуудлаа анхаарах хэрэгтэй. Хүний эрх хаана зөрчигдөж байна. Тэрний төлөө явах хэрэгтэй. Мэдээлэл та нарт хүрэхгүй байгаа гэж байхгүй шүү дээ. Бүх мэдээлэл хүрч байгаа, хүн болгонд хүрч байгаа. Өнөөдрийн мэдээллийн орчинд. Тэгээд ингээд ийм болж бүтэхгүй асуудлууд зөндөө л байна, энэ дотор. Маш их анхаарах ёстой асуудлууд байна. Тэгээд энэ шөнө орой мессеж бичээд лобби хийж байдаг Хунан, Сүнжид, Мөнхзул, Энхболд, Нарантуяа лобби хийж. Гэтэл томилогдсоноосоо хойш хүний эрх зөндөө зөрчигдсөн шүү дээ. Энэ дээрээ л лобби хийж, шөнө орой мессеж бичиж үүнийхээ төлөө хөөцөлдөх хэрэгтэй шүү дээ. Гэтэл тэгсэн үү, ингэж ажиллах хэрэгтэй.

Маш их дэмжиж, маш их урам зориг өгч та нарыг томилсон шүү дээ. Хуулиараа бүх эрх чинь байна. Одоо ажиллах хэрэгтэй. Хүний эрхийн комиссын өмнөх гишүүн маш их шүүмжлэлд өртөөд л, болж бүтэхгүй үйл ажиллагаа хийдэг хүн амьтан дарамталдаг сүрдүүлдэг. Тийм юм бас үнэн шүү дээ. Гэтэл үүнийг нь бүгдийг, бүх юмыг ингэж хорьж яах гэж байгаа юм.

Г.Занданшатар: Санал хэллээ. Гишүүд асуулт асууж, хариулт авч дууслаа.

Одоо санал хураалтад явуулна. Түүний өмнө дэмжсэн, дэмжээгүй гурав хүртэл гишүүн үг хэлж болно. Дэмжсэн 3, дэмжээгүй 3 гишүүн үг хэлж болно.

Үгийн саналуудыг авъя. Цогтбаатар гишүүнээр тасаллаа. Бусад танхимуудаас гишүүдийн нэрсийг нэгтгэж өгөөрэй. Ингээд Төмөрбаатарын Аюурсайхан гишүүн.

Т.Аюурсайхан: Хүний эрхийн тулгамдсан асуудлуудыг шийдэх ёстой. Энэ олон улсын конвенцын зорилтуудыг хууль тогтоомждоо шингээж өгөх ёстой. Хүний эрхийн үндэсний комисс сайн ажиллах ёстой. Өмнөх арга барилаасаа салах ёстой. Ийм ч учраас сонгон шалгаруулж, та бүхнийг томилсон, ажилд чинь оруулсан. Энэ ажлаа сайн хийх хэрэгтэй. Бүх хуулийн хүрээ нь байж байгаа, тэр хүний эрх хамгаалж байгаа хүмүүсийг хамгаалах хууль тогтоомж, хүчин төгөлдөр хуулиуд дээрээ тусчихсан байгаа. Зохих дахиад нэмэлт шаардлагатай гэх юм бол үндэсний комиссынхоо хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулж болно.

Гагцхүү энэ хуулиудын хоорондын зөрчилдөөн оруулсан, хийдэл гаргасан энэ Засгийн газрын тэмдэглэл дээр маш тодорхой заасан байна шүү дээ. Тэгээд энэ хороо гэж байгаа юм. Тийм ээ, Хүний эрх хамгаалагчийг хамгаалах хороо гээд. Тэгээд хараат бус гэсэн мөртөө Хүний эрхийн үндэсний комиссын гишүүн ах түүнийг даргалдаг, үндэсний комиссын дэргэд ажилладаг. Тэгээд энэ ажил хийх боломж чинь бол дутаагүй ээ. Шинэлгээр санаачлагатайгаар хийх хэрэгтэй. Энэ хуулийн төсөл дотроо маш олон эргэлзээтэй асуудлууд их байгаа. Ер нь хуулийн төслөөрөө хүний эрх хамгаалагч гэж ганцаараа, эсвэл бусадтай эвлэлдэн нэгдэж, хүний эрх, эрх чөлөөг эдлүүлэхийг хөхүүлэн дэмжиж, хамгаалахад оролцож байгаа хүнийг гэж байгаа. Тэгэхлээр хүний эрхийн төлөө дуугарч байгаа хүн болгон л хүний эрх хамгаалагч гэсэн үг. Энэ үйлсэд бол хувь нэмрээ оруулж байгаа гэсэн үг.

Тэгээд энэ өргөн хүрээтэй үүнийгээ бусад хуульдаа нийцүүлээд засаж сайжруулаад, шаардлагатай бол өргөн барих хэрэгтэй. Тэгээд энэ маш олон хуулиуд дээр тэртээ тэргүй заачихсан асуудлуудыг дахиад л одоо энэ хүмүүсийг мөрдөж мөшгиж болохгүй. Хуурч мэхэлж залилж болохгүй. Бүгд л одоо гадуурхаж болохгүй, тийм ээ. Энэ гүтгэж болохгүй гээд л хүчин төгөлдөр хууль тогтоомжоороо заачихсан байгаа шүү дээ. Монгол Улсын Ерөнхийлөгчийг хүртэл Ерөнхийлөгчийн эрхийн тухай хууль гээд ингээд ийм юм батлаад байвал юу болох вэ? Бүгд л иргэнийхээ хувьд энэ хүчин төгөлдөр хууль тогтоомждоо захирагдаад л ажиллана шүү дээ. Тэгээд ер нь цаашдаа санаачлагатай ажиллах хэрэгтэй. Шалтаг шалтгаан хэлээд ингэж бас ажилламааргүй байна. Шинэлэг байдлаар идэвхтэй ажилла гэж та нарыг томилсон байгаа. Түүнийхээ төлөө хүмүүстээ хүрч ажилла аа. Томилогдсоноос чинь хойш энэ хүмүүсийн хамгийн дээд эрх байгаа шүү дээ. Амьд явах эрх гээд. Эрүүл мэндээ хамгаалуулах эрх энэ олноор зөрчигдөж байхад дуугарч байхгүй юугаа хийж байна, өнөөдрийг хүртэл ажиллаж байгаа юм.

Тэгсэн мөртөө одоо өөрсдийгөө хамгаалуулах гэдэг ийм юм. Тэртэй, тэргүй хуулиар хамгаалалт чинь байхад чинь. Ингээд дахин, дахин одоо ийм асуудал оруулаад л шөнө орой мессеж бичээд л одоо үүнийгээ цаашдаа анхаарах хэрэгтэй, мэдээ. Ийм байдлаар одоо ажилламаар байна. Тэгээд энэ Засгийн газрын саналтай санал нэг байна. Энэ дээр бас нэлээн том хуулиудын зөрчлүүд үүсэж байна. Энэ гол санааг нь бол үгүйсгэхгүй байна. Хүний эрхийг хангах ёстой, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ёстой. Гэхдээ үүнийгээ одоо хүчин төгөлдөр хууль тогтоомждоо зохих өөрчлөлтийг оруулах бас боломж нь байгаа шүү дээ.

Г.Занданшатар: Дэмжихгүй үг хэллээ. Одоо Цэрэнжамцын Мөнхцэцэг гишүүн Жанжин Д.Сүхбаатарын танхим.

Ц.Мөнхцэцэг: Хуулийн төслийг зарчмыг хувьд дэмжиж байна. Энэ хүний эрхийг хамгаалах, хүний эрхийн хамгаалагчийг хамгаалах тухай энэ асуудал маань олон улсын чиг хандлага байгаа. Дэлхий дахины одоо ардчилсан хүний эрхийг дээдэлдэг улс орнуудын. Ер нь улс орнуудын практикаас харахаар одоо хүний эрхийн хамгаалагчийг хоёр янзаар хамгаалсан эрх зүйн зохицуулалт байгаад байгаа. Эхнийх нь энэ тусгайлан хууль гаргаад байна. Ихэнхдээ европ, баруун европ болон Америкийн нэгдсэн улс, хойд америкийн жишээ. Тэгээд тусгайлсан хуулиараа тухайн хүний эрхийн хамгаалагчийн эрх зүйн болон эрхийн бусад заалтуудыг зохицуулж өгдөг.

Хоёрт нь болохоороо ерөнхийдөө Ази дахин гэдэг юм уу, зарим нэг автротари дэглэмтэй улс орнуудад тусгайлсан хууль гаргахгүйгээр хууль тогтоомждоо шингээгээд явдаг ийм жишиг байгаад байна. Тэгэхээр, манайх бол энэ хуулийг ингээд батлаад оруулбал энэ олон улсын хүний эрхийн тогтолцоог Монголдоо нутагшуулж байгаа ийм үр дагавартай. Тэгээд энэ олон улсын байгууллагууд, урьд өмнөх 30 жилийн практикт хүний эрхийн төлөө тэмцэж байсан, байгаль хамгаалах гэдэг юм уу янз бүрийн асуудлаар тэмцэж ирсэн олон хүмүүс дарамт шахалт, тэр байтугай зарим нь амь насаа алдаж байсан ийм одоо гашуун практик байгаа.

Тийм учраас бид нар, энэ иргэний нийгмийн байгууллагууд, хүний эрхийн тэмцэгч нарыгаа хамгаалах эрх зүйн зохицуулалтыг төр одоо авах нь зүйтэй. Тэгээд 1998 оны хүний эрхийн түгээмэл тунхаглалын 50 жилийн ойгоор НҮБ-аас баталсан хүний эрхийн хамгаалагчийн тухай тунхаглалд төр бол энэ үүргийг хүлээнэ гэдэг ийм заалт гаргасан ийм олон улсын жишиг, олон улсын эрх зүйн зарчмууд бол байгаа. Тийм учраас бид нар энэ хуулийг одоо хэлэлцээд батлаад явах ёстой байх. Сая гишүүдийн маань хэлж байгаа энэ саналуудыг ажлын хэсэг, мөн мэргэжлийн судлаачид нэлээн ажиллаж бүр сайн боловсруулах шаардлагатай болов уу гэсэн байр суурьтай байна.

Г.Занданшатар: Мөнхцэцэг гишүүн ажлын хэсэгт ажиллаарай. Одоо Одонгийн Цогтгэрэл гишүүн, Их засаг танхимаас.

О.Цогтгэрэл: Товчоор бол үзэл баримтлалынхаа хувьд энэ хуулийн төслийг дэмжиж байгаа. Тэгэхдээ яг энэ байдлаараа хууль болоод гарахад бас их учир дутагдалтай л байгаа юм шиг харагдаж байна л даа. Ингээд зарим зарим заалтуудыг харахад, одоо байгаа нэгэнт хуулиар бусад хуулиудаар өгөгдсөн эрхүүдийг тэр чигээр нь ингээд дурдаад биччихсэн. Тэр хуулиуд дээр ахиц гарахгүй байдлууд харагдаад байгаа юм. Би нэг жишээ болгоод хэдийг бичсэнээс ганц, хоёрыг нь харъя. Жишээ нь, хүний эрх хамгаалагч нь мэдээлэл авах, ирж хайх түгээх эрхтэй л гэчихсэн байна. Энэ чинь одоо Үндсэн хуулиар бид нарт олгогдчихсон эрх. Гэтэл энэ хууль дээр жишээ нь тэр төрийн албаны нууцлалын тухай гэх мэт дагалдах хуулиудад тэр боломж бололцоог нь нээж өгөхгүйгээр

нэгэнт байгаа хуулийн харилцаа юм шиг. Дахиад жишээ нь одоо энэ дээр жагсаал цуглаан хийх эрхтэй гэчихсэн байна. Гэтэл яг энэ жагсаал, цуглаан хийх эрх дээр том ахиц гаргахын тулд, жишээ нь жагсаал цуглааныг зөвхөн мэдэгдсэний үндсэн дээр хийдэг ч юм уу. Магадгүй иймэрхүү зүйл гарч байж энэ нь хуулийн төсөлд, өөр дагалдах хуулиуд өөрчлөгдөж байж энэ хууль чинь өөрөө тийм, өөрийнхөө үүргийг биелүүлэх юм шиг. Жишээ нь, дараа нь хүний эрхийг хамгаалагчид сэтгэл санааны хохирлоо арилгуулах эрхтэй гэж. Гэтэл энэ сэтгэл санааны хохирлыг яаж арилгах юм? Энэ чинь үүнийг үнэлж тооцож байж, нөгөө талд нь шүүхээс шийдвэр гарч байж сэтгэл санааны хохирол гэдгийг арилгана.

Тэгэхээр энд ингээд нэг ийм тунхаглалын шинжтэй маш их олон зүйл заалт байна. Яг энэ энэ чигээрээ гарчихвал тийм шинээр хуулийн боломж бололцоо авчраагүй зүйл маш их харагдаж байна л даа. Тэгэхдээ энэ дээрээ нэлээн анхаарч ажилламаар юм шиг л харагдаж байна. Зарчмын хувьд дэмжиж байна.

Г.Занданшатар: Дэмжсэн үг хэллээ. Ингээд хоёр гишүүн дэмжсэн үг хэлсэн. Одоо Цэрэнпилийн Даваасүрэн гишүүн.

Ц.Даваасүрэн: Баярлалаа. Энэ хууль дээр миний эргэлзээд байгаа юм бол Хүний эрхийн үндэсний комиссын үйл ажиллагаатай давхцаж байгаа юмнууд байна, тэр хүрээнд зохицуулах болох байсан байх гэж. Хүний эрхийг хамгаалагч гэдэг чинь өөрөө хэн байх юм бэ гэдэг асуудал чинь энэ дээр дэндүү өргөн хүрээтэй болчихсон юм байна. Тэгээд яг одоо хэн энэ хүний эрхийг хамгаалагч мөн гэж хэлэх юм гэдэг чинь хүртэл бас энэ хууль дээрээ байхгүй юм байна. Тэгээд тэмцэж байгаа хүн гээд байвал хэн ч байж болохоор. Тэгээд их өргөн хүрээтэй эрх олгочихож байгаа шүү дээ, тэр хүний эрхийг хамгаалагч гэдэг дээр чинь. Тэгэхээр одоо жагсаал цугтаад оролцож байгаа бүх хүнд хүний эрхийг хамгаалагч болоод явчих юм уу. Түүн дотроо одоо энэ нь мөн гээд тэр нэг байгуулагдсан хороо нь хэлэх юм уу. Энэ чинь боловсруулалтын хувьд бол учир дутагдалтай хууль орчихсон юм байна.

Тэгээд би хэлэлцэх эсэхийг бол дэмжихгүй байна. Ингээд хэлэлцэгдэхээр бол ажлын хэсэг дээрээ үүнийг нэлээн сайн ярьж, ингэж гаргахгүй бол энэ хуультай холбогдолтой олон хуулийн зөрчлүүд байна. Тэгэхээр энэ хүний эрхийг хамгаалагч гэж нөхрийн тэр эрхэн дотор бусад хуулиудтай зөрчилдсөн нэлээн юмнууд орчихсон байна. Тэгэхээр энэ энийгээ зохицуулах асуудал байна. Тэгээд цаашдаа Хүний эрхийн үндэсний комиссоо яаж авч явах юм гэдэг юм. Тэгээд энэ хоёр чинь хоорондоо холилдож байгаа юм шиг байна. Хороогоороо дамжаад гэх мэтийн. Хуулийн төсөл хэрвээ дэмжигдвэл энэ дээр нэлээн анхааралтай, нэлээн ажил хэрэгч ингэж хандахгүй бол замбараагүй нэг тийм байдал руу бас хөтөлсөн. Хүний эрхийг хамгаалагч гээд ингээд бүр бужигнуулсан жагсаал, цуглаан байнга зохион байгуулдаг нэг ийм юмнууд. Мөнгөтэй хүний хармааны хамгаалагч гарч ирэх вий дээ гэдгийг би бас болгоомжилж байгаа учраас хэлье гэж ингэж бодож байгаа юм. Баярлалаа.

Г.Занданшатар: Хоёр дэмжихгүй, хоёр дэмжсэн үг хэлсэн. Сайнбуянгийн Амарсайхан гишүүн Эзэн чингис хааны танхимаас.

С.Амарсайхан: Хүний эрхийг хамгаалагч гэдэг бол өөрөө өөрийнхөө ч эрхийг хамгаалах ёстой, хүний ч эрхийг хамгаалах ёстой. Бүр нарийн яривал өөрийнхөө эрхийг хамгаалж чадахгүй хүн, хүний эрхийг хэрхэн хамгаалах вэ гэдэг асуудал зүй ёсоор гарч ирнэ. Нөгөө талдаа хууль сахиулах байгууллага, цагдаа, хууль хүчний байгууллагууд хүртэл хүний эрхийг хамгаалдаг нэг байгууллагын нэг хэлбэр. Тэгээд хууль сахиулж байгаа хүмүүсийг бас хамгаалах байгууллага гээд байгуулагдах асуудал яригдах уу гэдэг асуудал ч бас яригдахыг үгүйсгэхгүй. Гэхдээ энэ хүний эрхийг хамгаална гэдэг нь хэн нэгний эрхийг хамгаалах гэхээсээ илүүтэй нийтийн эрх ашгийг хамгаалахад нэн чухал асуудал учраас би энэ асуудлыг хэлэлцэхийг дэмжиж байгаа. Нэгдүгээрт.

Хоёрдугаарт, аливаа этгээдийн эрхийг хамгаална гэдэг нь өөрөө хуулиар олгогдсон хэн нэгний эрхийг хамгаалахаас гадна бас бусдын хууль, нийгмийн өмнө хүлээсэн үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд, нийтийн эрх ашгийг хамгаалахад, бүр цаашилбал албан тушаалтны үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхэд бас л өндөр ач холбогдолтой учраас энэ хүний эрхийн асуудалтай холбоотой, хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах асуудлыг бас хэлэлцээд буруу, зөвийг нь засаад явах ёстой гэж бодож байгаа. Яагаад гэвэл энэ хүний эрхийг хамгаалагч чинь өөрсдөө бас хүн. Өөрсдийн нэр төр, алдар хүнд, амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгө гээд Үндсэн хуулиар болон НҮБ-ын тунхаглалд өртсөн эрхээ эдэлж байж хүний эрхийг хамгаална.

Хүний эрхийг хамгаалагчдыг бас хамгаалахгүйгээр бусдын эрхийг нийтийн, одоо үндэсний хэмжээнд гэдэг юм уу олон улсын хэмжээнд хамгаална гэвэл орчин нөхцөл нь өөр өөр байдаг учраас эрсдэл бас харилцан өөр байдаг учраас хүний эрхийг хүндрэл бэрхшээлтэй, бослого, үймээнтэй газар бол зайлшгүй хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалах ийм асуудал хөндөгдөж ирсэн. Манай орчин бол харьцангуй тайван. Дээрээс нь иргэншсэн нийгмийн энэ хүний эрхийн асуудлыг хангахад элдэв янзын асуудал гардаг учраас үүнийг хангаж явах ёстой гэж бодож байгаа. Гэхдээ энэ дээр бас анхаарах зүйлүүд бий. Яагаад хүний эрхийн эрхийг хамгаалагчдыг бас хамгаалах ёстой вэ гэхээр энэ дээр бас хамгаалж байгаад өөрөө бизнес, улс төрийн бүлэглэлд хууль барьсан бүлэглэл этгээдүүдэд нэр төр, алдар хүндээ гутаалгадаг ийм асуудал гарч байгаа шүү дээ. Саяхан хүртэл одоо Хүний эрхийн комиссын гишүүн Оюунчимэг гэдэг хүнийг элдвээр гүтгэж, доромжлоод, шантаажлаад л байсан. Тэр нь хуулийн байгууллагаар гүтгэлэг байсан гэдэг нь тогтоогдсон юм байна. Тэгээд бусдын төлөө явж байгаад өөрсдийнхөө эрх ашгийг хөндлүүлээд.../хугацаа дуусав/.

Г.Занданшатар: Амарсайхан гишүүн үгээ гүйцээгээд хэлчих.

С.Амарсайхан: Тэгээд бусдын эрх ашгийг хамгаалах гэж байна гэж явж байгаад аливаа этгээдүүдийн заналд орж наад зах нь нэр төр, цаад тал нь ажил амьдрлаараа хохирдог том жишээ байна шүү дээ. Тэгээд өнөөдөр ажилгүй болчихсон явж байгаа. Түүнээсээ шалтгаалаад Хүний эрхийн комиссын зарим асуудал ч оруулахаа больчихсон. Нөгөө талаар эцэст нь хэлэхэд бол бас энэ хүний эрхийг хамгаалагчид өөрсдөө сайн ажиллах ёстой шүү гэж сая гишүүд хэлж

байна. Алхам тутам эрсдэл бий. Алхам тутам хүний эрх зөрчигдөж байгаа. Үүний нөгөө талд хүний үүрэг хариуцлага байгаа гэдгийг ярихгүйгээр, дандаа эрх ярьдаг чинь өөрөө энэ эрхийг хэрэгжүүлэх та нарын ажлыг хүчгүйдүүлж байгаа шүү гэдгийг санаж өдөр тутам энэ эрхийг хамгаалах ажил дээрээ анхаарч ажиллаарай л гэж хэлж байна.

Г.Занданшатар: Хүний эрхийн үндэсний комисс, хүний эрхийн үндэсний комиссын гишүүнээр ажиллаж байсан хүнийхээ эрхийг хамгаалах асуудлыг шүүхээр шийдвэрлэгдчихээд байхад үүнийг анхааараарай. Сая Амарсайхан гишүүний хэлж байгаа зөв, үнэн бодит байдал. Шүүхээр тогтоогдчихсон мөртөө хэлмэгдээд яваад байдаг.

Ингээд 3 гишүүн дэмжсэн үг хэлсэн учраас Цогтбаатар гишүүн хууль санаачлагч эсэргүүцэхгүй байх хаслаа.

Баатарбилэг гишүүн дэмжээгүй үг хэлж болно. Тэгэхдээ үг аваад дуусчихсан байна. Тийм учраас одоо санал хураалт явуулна. Гишүүд дэмжсэн дэмжээгүй үг хэлж дууслаа. Мэтгэлцэж дууслаа.

Одоо Хүний эрх хамгаалагчийн эрх зүйн байдлын тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулна.

Гишүүдийн хэлсэн үгтэй холбогдуулаад хэлэхэд хууль дээр сайжруулах, Бусад хуультай уялдуулах ийм олон санал санаачилгууд бол гарсан. Тэгэхдээ үүнийг хэлэлцэх эсэхийг нь хэлэлцчхээд энэ НҮБ-ын Хүний эрхийн конвенц, НҮБ-ын Хүний эрхийг хамгаалагч комиссар Монгол Улсад ирээд тавьсан хүсэл зэргийг харгалзаад энэ хуулиа хэлэлцэх эсэхийг дэмжээд явъя гэсэн ийм саналыг хэлж гишүүдийг уриалж байна. Ажлын хэсэг байгуулаад ажлын хэсэг дээрээ ажиллаад явъя гэж Хууль зүйн байнгын хорооны даргын гаргасан саналыг бас дэмжиж байна. Тэгээд ийм зарчим баримтлаад явъя.

Ингээд тестийн санал хураалт явуулъя.

Саяны хуулийг түрүүний уншсан байдлаар Байнгын хороо дэмжих саналын томьёоллоор санал хураалт явуулна. Тэгээд Байнгын хорооны саналаар хэлэлцэх нь зүйтэй гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Миний саналыг дэмжсэнд тооцоорой. Энэ манай төхөөрөмж ажиллахаа болчихлоо, протоколд тусгая.

Санал хураалтад 63 гишүүн оролцож, 44 гишүүн дэмжиж, гишүүдийн олонх нь төслийг хэлэлцэх нь зүйтэй гэж үзлээ. Тэр хувь өөрчлөгдөх учраас миний саналыг нэмээд тооцчихоорой.

Төслүүдийг хэлэлцэх нь зүйтэй гэж гишүүдийн олонх үзсэн тул төслүүдийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн тооцон анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Хууль зүйн байнгын хороонд шилжүүлж байна.